

ҮАБЗ-ИЙН СТРАТЕГИ СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

ОХУ-ЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТРАТЕГИ

Албан бус орчуулга

2022 оны 02 сар

АГУУЛГА

Оршил	3
ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегийг батлах тухай Оросын холбооны улсын зарлиг	5
Нэг. Ерөнхий заалтууд	6
Хоёр. Орчин үеийн ертөнц дэх Орос улс: чиг хандлага ба боломжууд	7
Гурав. ОХУ-ын Үндэсний ашиг сонирхол, Үндэсний стратегийн тэргүүлэх чиглэлүүд	10
Дөрөв. Үндэсний аюулгүй байдлыг хангах	11
Тав. Энэхүү стратегийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын үндэс, механизм	33



ОХУ-ЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТРАТЕГИ

Орчуулсан Д.Эрдэнэцогт
ҮАБЗ-ийн ССХ-ийн ОУЦСАБСТ-ийн ахлах шинжээч,
цэргийн шинжлэх ухааны доктор, хурандаа

ОРШИЛ

ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын суурь баримт бичиг болох “Үндэсний аюулгүй байдлын стратеги”-ийг ОХУ-ын ерөнхийлөгч В.Путины 2021 оны долоодугаар сарын 02-ны өдрийн 400 тоот зарлигаар¹ “шинэчлэн баталсан бөгөөд нийт 5 бүлэг, 106 зүйлтэй энэхүү стратегийн онцлог нь Оросын ард түмнийг үндэсний ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдлын тэргүүлэх чиглэлийн хамгийн эхэнд тавьсан явдал байлаа.

Тус стратегид АНУ, НАТО түүний холбоотнуудын зүгээс цэрэг армийн дэд бүтцээ хөгжүүлж, Оросын хилийн ойролцоо төвлөрүүлэх, тагнуулын үйл ажиллагааг идэвхжүүлэх, цөмийн зэвсэг үйлдвэрлэх зэргээр хүчний шахалт үзүүлж байгаа нь тус улсын батлан хамгаалахын аюулгүй байдалд аюул занал учруулж байна хэмээн үзжээ. Дээрх аюул заналхийллийг ОХУ-ын зүгээс стратегийн тогтоон барих бодлого хэрэгжүүлэх, шинэ зэвсэглэл зохион бүтээх, эдийн засгаа бэхжүүлэх, төрийн байгууллага, ард иргэдийг болзошгүй дайн, зэвсэгт халдлагад бэлэн байлгах, иргэдэд цэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх зэргээр саармагжуулна хэмээн үзэж байна.

Мөн ОХУ-ын мэдээллийн орон зайд тагнуулын болон бусад ажиллагаа явуулах гадаад орнуудын тусгай албадын үйл ажиллагаа эрчимжиж, ОХУ-ын онц чухал мэдээллийн дэд бүтцийг идэвхгүй болгох, саармагжуулах ажиллагаа, үндэстэн дамнасан корпорацууд интернэтэд монополь байр сууриа бэхжүүлж, цензурыг нэвтрүүлэх, ижил төстэй платформуудыг хууль эрх зүйн үндэслэлгүйгээр хаах, хязгаарлах үйл ажиллагааг явуулж байгаа зэрэг мэдээллийн аюул заналхийллийг тодорхойлсон. Оросын интернэтийн аюулгүй байдлыг сайжруулах, хувийн мэдээллийн алдагдлыг хамгийн бага түвшинд хүргэх, мэдээллийн технологийн дэд бүтцэд Оросын технологи, тоног төхөөрөмжийн тэргүүлэх хэрэглээг хангах зорилго бүхий мэдээллийн аюулгүй байдлын дэд бүлгийг шинээр оруулжээ.

Тус стратегид гадаад худалдаан дахь ам.долларын хэрэглээг багасгах, өндөр

¹ Указ Президента Российской Федерации от 02.07.2021 № 400 “О Стратегии национальной безопасности Российской Федерации”

технологид суурилсан эдийн засгийг хөгжүүлэх, нүүрс устөрөгчийн эрчим хүч гаргаж авах зэрэг шинэлэг асуудлуудыг оруулснаас гадна шинжлэх ухааны чадавхыг хөгжүүлэх, боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах нь Оросын эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хурдасгана гэж үзсэн байна.

Шинжлэх ухаан, технологийн хөгжлийг улсын хяналтад байлгах талаар стратегид тусгасан нь үндэсний эрдэмтдийн бүтээсэн шинэ технологийн нууцыг гадаадын тусгай албадаас хамгаалахад онцлон анхаарч буйг харуулж байна. Мөн эрдэмтэд болон бизнесийн салбарыг инновацид нэгтгэснээр төрийн мэдлийн шинжлэх ухаан, технологи инновацийн нэгдсэн өгөгдөл системтэй болж технологийн хараат байдлаас ангижрах, шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагааг батлан хамгаалахын салбартай уялдуулах зорилт тавьжээ.

ОХУ-ЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТРАТЕГИЙГ БАТЛАХ ТУХАЙ ОРОСЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн ОХУ-ын Аюулгүй байдлын тухай, 2014 оны зургаадугаар сарын 28-ны өдрийн ОХУ-ын Стратегийн төлөвлөлтийн тухай Холбооны хууль тогтоомжийг үндэслэн:

1. ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегийг хавсралтаар баталсугай.
2. ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 683 тоот «ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын стратегийн тухай» зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.
3. Энэхүү зарлиг нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

ОХУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ В.ПУТИН

Москвагийн Кремль

2021 оны 7 дугаар сарын 2

№ 400

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТРАТЕГИ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗААЛТУУД

1. ОХУ-ын батлан хамгаалах чадавх, дотоод эв нэгдэл, улс төрийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засгаа шинэчлэх, аж үйлдвэрийн чадавхыг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй тууштай чиглэл нь гаднын аливаа шахалт оролдлогыг үр дүнтэй эсэргүүцэх, ОХУ-ын бие даасан гадаад, дотоод бодлого явуулах чадвартай улсын бүрэн эрхт төрт ёсны бэхжилтийг хангаж байна.

ОХУ-ын Үндсэн хуульд Оросын нийгмийн үндэс суурийг бүрдүүлдэг үндсэн үнэт зүйл, зарчмуудыг тусгасан байдаг нь улс орны аюулгүй байдал, Орос улсыг хүний эрх, эрх чөлөөг сахин хамгаалах, эрх зүйн ба нийгмийн шинжтэй улс болгон хөгжүүлэх, хүн ба иргэний харилцаа, ард түмний сайн сайхан байдлыг дээшлүүлэх, ОХУ-ын иргэд (цаашид иргэд)-ийн нэр төрийг хамгаалах нэн чухал үндсийг бүрдүүлж байна.

Хүчирхэг төр, иргэдийн сайн сайхан байдлын эв нэгдэлтэй хослол нь шударга нийгмийг бүрдүүлж, Оросын хөгжил цэцэглэлтийг хангах болно. Энэ нь гадаад, дотоод аюул заналхийллийг саармагжуулах, үндэсний хөгжлийн зорилтод хүрэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн ОХУ-ын үндэсний стратегийн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн уялдаа холбоотой үйл ажиллагааг шаардаж байна.

2. Энэхүү стратеги нь ОХУ-ын үндэсний ашиг сонирхол, стратегийн үндэсний тэргүүлэх чиглэл, ОХУ-ын урт хугацаанд үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр төрийн бодлогын зорилго, зорилтыг тодорхойлсон стратеги төлөвлөлтийн үндсэн баримт бичиг мөн.

3. Энэхүү стратеги нь ОХУ-ын үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн салшгүй харилцаа, харилцан хамаарал дээр суурилна.

4. Энэхүү Стратегийн эрх зүйн үндэс нь ОХУ-ын Үндсэн хууль, 2010 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн «Аюулгүй байдлын тухай», 2014 оны зургаадугаар сарын 28-ны өдрийн «ОХУ-ын Стратеги төлөвлөлтийн тухай» холбооны хууль юм.

5. Энэхүү стратегид дараах үндсэн ойлголтуудыг ашигласан болно.

1) ОХУ-ын үндэсний аюулгүй байдал (цаашид үндэсний аюулгүй байдал) нь ОХУ-ын үндэсний ашиг сонирхлын гадаад, дотоод аюулаас хамгаалагдсан байдал бөгөөд энэ нь иргэдийн үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө, амьдралын түвшин, нэр төрийн үнэлэмж, улс түмний энх тайван, эв найрамдал, ОХУ-ын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, төрийн бүрэн бүтэн байдлын хамгаалалт, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангаж байгаа байдал;

2) ОХУ-ын үндэсний ашиг сонирхол нь аюулгүй байдал, тогтвортой хөгжилд хувь хүн, нийгэм, улсын объектив чухал хэрэгцээ;

3) ОХУ-ын үндэсний стратегийн тэргүүлэх чиглэлүүд (цаашид - үндэсний стратегийн тэргүүлэх чиглэлүүд) нь ОХУ-ын үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах хамгийн чухал чиглэлүүд;

4) Үндэсний аюулгүй байдлыг хангах гэдэг нь төрийн эрх баригчид иргэний нийгмийн институт, байгууллагуудтай хамтран үндэсний аюулгүй байдалд заналхийлж буй заналхийлэлтэй тэмцэхэд чиглэсэн улс төр, хууль эрх зүй, цэрэг, нийгэм-эдийн засаг, мэдээлэл, зохион байгуулалтын болон бусад арга хэмжээний хэрэгжүүлэлт;

5) Үндэсний аюулгүй байдлын заналхийлэл нь ОХУ-ын үндэсний ашиг сонирхолд шууд болон шууд бусаар хохирол учруулах боломжийг бий болгож буй нөхцөл байдал, хүчин зүйлийн цогц;

6) Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрийн бодлогыг хэрэгжүүлж буй төрийн эрх бүхий байгууллагууд, тэдгээрийн мэдэлд байгаа хүч хэрэгслэл.

ХОЁР. ОРЧИН ҮЕИЙН ЕРТӨНЦ ДЭХ ОРОС УЛС: ЧИГ ХАНДЛАГА БА БОЛОМЖУУД

6. Орчин үеийн ертөнц өөрчлөлтийн үеийг туулж байна. Дэлхийн эдийн засаг, улс төрийн хөгжлийн төвүүдийн тоо нэмэгдэж, дэлхийн болон бүс нутгийн шинэ тэргүүлэх орнуудын байр суурь бэхжиж байгаа нь дэлхийн дэг журмын бүтцийг өөрчлөх, дэлхийн шинэ архитектур, дүрэм, зарчмуудыг бий болгоход хүргэж байна.

7. Барууны орнуудын ноёрхлоо хадгалах хүсэл эрмэлзэл, эдийн засгийн хөгжлийн орчин үеийн загвар, арга хэрэгслийн хямрал, улс орнуудын хөгжлийн пропорциональ бус байдлын өсөлт, нийгмийн тэгш бус байдлын түвшний нэмэгдэл, үндэстэн дамнасан корпорациудын сонирхол нь төрийн үүрэг ролийг хязгаарлаж байгаа төдийгүй дотоодын улс төрийн асуудлуудыг хурцатгаж, улс хоорондын зөрчилдөөнийг нэмэгдүүлж, олон улсын байгууллагуудын нөлөөг сулруулж, дэлхийн аюулгүй байдлын тогтолцооны үр ашгийг бууруулж байна.

8. Дэлхийд өсөн нэмэгдэж буй тогтворгүй байдал, радикал, хэт даврагч үзэл санааны өсөлт нь улс хоорондын зөрчилдөөнийг дотоод, гадаад дайснаа хайх замаар шийдвэрлэх оролдлого, эдийн засаг, уламжлалт үнэт зүйлсийг нураах, хүний үндсэн эрх, эрх чөлөөг үл тоомсорлоход байдалд хүргэж болзошгүй байна.

9. Геополитикийн хурцадмал байдал нэмэгдэж байгаа нөхцөлд ОХУ-ын гадаад бодлого нь олон улсын эрх зүй, нийтлэг, тэгш, хуваагдашгүй аюулгүй байдлын зарчимд

суурилсан олон улсын харилцааны тогтолцооны тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, олон талт хамтын ажиллагааг блокын хандлага зааг ялгаагүйгээр гүнзгийрүүлэхэд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) болон түүний Аюулгүйн Зөвлөлийн зохицуулах төв үүргийн оролцоотойгоор дэлхийн болон бүс нутгийн асуудлыг хамтран шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах явдал мөн.

10. ОХУ-аас үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрийн бодлогыг хэрэгжүүлэх нь Оросын дотоод тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, эдийн засаг, улс төр, цэрэг, оюун санааны чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах бөгөөд энэ нь Оросыг орчин үеийн ертөнцийн нөлөө бүхий төвүүдийн нэг болох үүргийг бэхжүүлэхэд зайлшгүй шаардлагатай юм.

11. Одоогийн байдлаар Оросын нийгмийн эв нэгдэл бэхжиж, иргэний ухамсар бэхжиж, уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлсийг хамгаалах хэрэгцээ, ухамсар, иргэдийн нийгмийн идэвх өсч, орон нутгийн болон улсын ач холбогдолтой тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тэдний оролцоо нэмэгдэж байна.

12. Төрийн болон олон нийтийн аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, бүрэн эрхт байдал зохих түвшинд хангагдаж, террорист үйл ажиллагааны түвшин эрс буурсан болно. Цэргийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх нь ОХУ-ыг цэргийн аюул, цэргийн заналхийлэлээс хамгаалах баталгаа болж, ОХУ-ын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох оролдлогыг үр дүнтэй таслан зогсоож байна.

13. ОХУ эдийн засгийн тэсвэр хатуужил тогтвортой гэдгээ дэлхий дахинд харуулж, гаднын хориг арга хэмжээний дарамтыг тэсвэрлэх чадвартай гэдгээ нотоллоо. Эдийн засгийн гол салбаруудын импортын хараат байдлыг бууруулах ажил үргэлжилж, хүнс, эрчим хүчний аюулгүй байдлын түвшин нэмэгдлээ.

14. ОХУ-ыг эдийн засгийн хөгжлийн шинэ түвшинд гаргах, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилгоор хүн ам зүйн сөрөг хандлагыг даван туулах, эрүүл мэндийн салбарын тогтолцооны асуудлуудыг шийдвэрлэх, ядуурлыг бууруулах болон нийгмийг орлогын түвшингээр нь ангилах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн иж бүрэн арга хэмжээнүүд байна. Шинжлэх ухааны чадавхыг хөгжүүлэх, боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах нь Оросын эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хурдасгах болно.

15. ОХУ-ын үндэсний ашиг сонирхлыг гадаад, дотоод аюул занал, тэр дундаа гадаад улс орнуудын найрсаг бус үйлдлээс хамгаалахын тулд дэлхийн хөгжлийн урт хугацааны чиг хандлагыг харгалзан ОХУ-ын одоогийн ололт амжилт, өрсөлдөх давуу талыг ашиглах, үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай.

16. Дэлхийн тэргүүлэгч орнуудын эдийн засгийн зогсонги байдал, уналтын нөхцөлд дэлхийн мөнгө, санхүүгийн системийн тогтвортой байдал буурч, зах зээл, нөөц баялгийг олж авахын төлөөх тэмцэл эрчимжиж, шударга бус өрсөлдөөний арга хэрэгслийг ашиглах практик, хамгаалах арга хэмжээ, хориг арга хэмжээ нь ялангуяа санхүү, худалдааны салбарт улам өргөн хүрээтэй болж байна. Хэд хэдэн улс давуу тал олж авахын тулд Орос болон түүний түншүүдэд нээлттэй улс төр, эдийн засгийн дарамт шахалт үзүүлж байна. Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчныг хамгаалах асуудалд дэлхийн хамтын нийгэмлэгийн анхаарал нэмэгдэж байгаа нь Оросын компаниудын экспортын зах зээлд нэвтрэх боломжийг хязгаарлах, Оросын аж үйлдвэрийн хөгжлийг хязгаарлах, тээврийн

чиглэлд хяналт тогтоох, мөн Оросыг Арктикийг хөгжүүлэхээс сэргийлж байна.

17. Геополитикийн тогтворгүй байдал, мөргөлдөөн нэмэгдэж, улс хоорондын зөрчилдөөн эрчимжиж байгаа нь цэргийн хүч хэрэглэх аюул заналхийллийг дагалдаж байна. Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчмуудыг ганхуулж, одоо байгаа олон улсын эрх зүйн байгууллагуудыг сулруулж устгах, зэвсгийн хяналтын чиглэлээр гэрээ, хэлэлцээрийн тогтолцоог тасралтгүй задлах нь хурцадмал байдлыг өөгшүүлж түүний дотор ОХУ-ын улсын хилийн ойролцоо цэрэгүлс төрийн тогтворгүй байдалд хүргэж байна. Зарим орны үйл ажиллагаа нь Оросыг уламжлалт холбоотнуудтайгаа холбоогоо таслахын тулд Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн (ТУХН) задралын үйл явцыг өдөөх зорилготой юм. Хэд хэдэн улс Оросыг тэдэнд учирч буй аюул занал гэж үзэн бүр цэргийн дайсан гэж нэрлэдэг. Зэвсэгт мөргөлдөөн орон нутгийн болон бүс нутгийн дайн, тэр дундаа цөмийн гүрнүүдтэй холбоотой дайн болж хувирах аюул улам бүр нэмэгдсээр байна. Сансар огторгуй, мэдээллийн орон зайг цэргийн ажиллагааны шинэ чиглэл болгон идэвхтэй судалж байна.

18. ОХУ-ыг тусгаарлах хүсэл эрмэлзэл, олон улсын улс төрд давхар стандартыг ашиглах нь дэлхийн хамтын нийгэмлэгийн бүх улс, тэр дундаа Европ дахь мөргөлдөөн, эрх тэгш, хуваагдашгүй аюулгүй байдлыг хангах, терроризм, экстремизм, хар тамхины бизнес, зохион байгуулалттай гэмт хэрэг, халдварт өвчний тархалт, олон улсын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчны асуудлыг шийдвэрлэх зэрэг дэлхийн хамтын нийгэмлэгийн чухал салбарт олон талт хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд саад учруулж байна.

19. Ёс суртахууны манлайллын асуудал, дэлхийн ирээдүйн дэг журамд сэтгэл татам үзэл суртлын үндэс суурийг бий болгох асуудал улам хурцаар тавигдаж байна. Барууны либерал загварын хямралын нөхцөлд хэд хэдэн улс уламжлалт үнэт зүйлсийг зориудаар бүдгэрүүлэх, дэлхийн түүхийг гуйвуулах, Орос улсын түүн дэх үүрэг, байр суурийг эргэн харах, фашизмыг сэргээх, угсаатны болон шашин шүтлэгийг өдөөн хатгах оролдлого хийж байна. Оросын дайсангаасан дүр төрхийг бий болгох зорилготой мэдээллийн кампанит ажил явагдаж байна. Орос хэлний хэрэглээг хязгаарлаж, Оросын олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаа, Оросын мэдээллийн нөөцийг ашиглахыг хориглож, Оросын тамирчдад хориг арга хэмжээ авч байна. ОХУ-ыг олон улсын өмнө хүлээсэн үүргээ зөрчсөн, компьютерын халдлага үйлдсэн, гадаад улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцсон гэж үндэслэлгүй буруутгаж байна. ОХУ-ын иргэд болон гадаадад амьдарч буй эх орон нэгтнүүд гадуурхагдаж, ил хэлмэгдүүлэлтэд өртөж байна.

20. Нөхөрсөг бус улс орнууд ОХУ-д байгаа нийгэм, эдийн засгийн асуудлуудыг ашиглан дотоод эв нэгдлийг нь эвдэж, эсэргүүцлийн хөдөлгөөнийг өдөөж, радикалжуулах, жижиг сажиг асуудлаар нэгдсэн бүлэг хүмүүсийг дэмжих, Оросын нийгмийг хагалан бутаргах гэж оролдож байна. ОХУ-д удаан хугацааны тогтворгүй байдлыг өдөөх шууд бус аргыг улам бүр ашиглаж байна.

21. Оросын Холбооны Улсыг хязгаарлах зорилтот бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан манай улсын бүрэн эрх, тусгаар тогтнол, төр, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бэхжүүлэх, Оросын нийгмийн уламжлалт оюун санаа, ёс суртахууны үндсийг хамгаалах, баглан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, ОХУ-ын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохоос урьдчилан сэргийлэх нь нэн чухал ач холбогдолтой.

22. ОХУ-ын дэлхийн хэмжээнд урт хугацаанд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийг

тодорхойлох гол хүчин зүйл нь хүний нөөцийн өндөр чанар, технологийн манлайллаар хангах чадвар, төрийн удирдлагын үр ашиг, эдийн засгийг шинэ технологийн үндэс бодлогод шилжүүлэх явдал юм. Шинжлэх ухаан, инноваци, аж үйлдвэр, боловсрол, эрүүл мэнд, соёл нь Оросын өрсөлдөх чадварын гол үзүүлэлт болж байна. Эдгээр салбарын тэргүүн эгнээнд улс орны батлан хамгаалах чадавхыг улам бэхжүүлэх, үндэсний хөгжлийн зорилтуудыг биелүүлэх, ОХУ-ын олон улсын нэр хүндийг өсгөх, түүнтэй хамтран ажиллах бусад улс орнуудын сонирхлыг татах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг багтах болно. Оросын өвөрмөц байдал, соёл, Оросын уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлс, иргэдийн эх оронч хүмүүжил нь ОХУ-ын ардчилсан бүтцийг цаашид хөгжүүлэх, түүнийг дэлхийд нээлттэй болгоход хувь нэмэр оруулна.

23. Дэлхийн дэг журмын шинэ архитектур, дүрэм, зарчмуудыг бүрдүүлэх нь ОХУ-ын хувьд зөвхөн шинэ сорилт, аюул заналхийлэл төдийгүй нэмэлт боломжуудыг бий болж байна. ОХУ-ын урт хугацааны хөгжлийн хэтийн төлөв, дэлхийд эзлэх байр суурь нь түүний дотоод чадавх, үнэт зүйлсийн тогтолцооны сэтгэл татам байдал, төрийн удирдлагын үр ашгийг дээшлүүлэх замаар өрсөлдөх давуу талаа хэрэгжүүлэх явдлын бэлэн байдал, чадвараар тодорхойлогдоно.

24. ОХУ нь дэлхийн хурцадмал байдлыг бууруулах, олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх, харилцан үйлчлэлийн механизмыг хөгжүүлэх, янз бүрийн хөгжлийн төвүүдийн ашиг сонирхлыг уялдуулах, олон талт эрх тэгш хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын нийтлэг институцуудыг бэхжүүлэх, эдийн засаг, худалдааны салбарт ажиллах дүрэм, нийтлэг хандлагыг хөгжүүлэхийн төлөө байна. Байр сууриа ойртуулж, дэлхийн ирээдүйн төлөөх нийтлэг хариуцлага хүлээх нь бүх улс оронд дэлхийн тулгамдсан асуудлуудыг хамтран шийдвэрлэх, дэлхийн улс орон, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг тэгшитгэх, хүн төрөлхтний ёс суртахуун, бие махбодийн эрүүл мэндийг хамгаалах илүү их боломжийг олгоно.

ГУРАВ. ОХУ-ЫН ҮНДЭСНИЙ АШИГ СОНИРХОЛ, ҮНДЭСНИЙ СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

25. ОХУ-ын болон дэлхийн нөхцөл байдлын хөгжлийн урт хугацааны чиг хандлагыг харгалзан өнөөгийн үе шатанд түүний үндэсний ашиг сонирхол нь:

1) Оросын ард түмнийг аврах, хүний чадавхыг хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанар, сайн сайхан байдлыг сайжруулах;

2) ОХУ-ын үндсэн хуулийн дэг журам, бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, төр, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, улс орны батлан хамгаалахыг бэхжүүлэх;

3) Улс оронд иргэний энх тайван, эв найрамдлыг сахин хамгаалах, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, авлигыг арилгах, иргэд, өмчийн бүх хэлбэрийг хууль бус халдлагаас хамгаалах, төр, иргэний нийгмийн харилцан үйлчлэлийн механизмыг хөгжүүлэх;

4) Аюулгүй мэдээллийн орон зайг хөгжүүлэх, Оросын нийгмийг хор хөнөөлтэй мэдээлэл, сэтгэлзүйн нөлөөллөөс хамгаалах;

5) Оросын эдийн засгийг шинэ технологийн үндсэн дээр тогтвортой хөгжүүлэх;

6) Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох;

7) Оросын уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлсийг бэхжүүлэх, Оросын ард түмний соёл, түүхийн өвийг хадгалах;

8) Стратегийн тогтвортой байдлыг хадгалах, энх тайван, аюулгүй байдал, олон улсын харилцааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх.

26. ОХУ-ын үндэсний ашиг сонирхлыг хангах, хамгаалах явдал нь дараах үндэсний стратегийн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд төрийн эрх мэдэл, байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын хүчин чармайлт, нөөцийг төвлөрүүлэх замаар хэрэгжинэ.

1) Оросын ард түмнийг аврах, хүний чадавхыг хөгжүүлэх;

2) Улс орноо хамгаалах;

3) Төрийн болон олон нийтийн аюулгүй байдал;

4) Мэдээллийн аюулгүй байдал;

5) Эдийн засгийн аюулгүй байдал;

6) Шинжлэх ухаан, технологийн хөгжил;

7) Байгаль орчны аюулгүй байдал, байгалийн нөөцийг зохистой ашиглах;

8) Оросын уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлс, соёл, түүхэн ой санамжийг хамгаалах;

9) Стратегийн тогтвортой байдал, харилцан ашигтай олон улсын хамтын ажиллагаа.

ДӨРӨВ. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

27. Үндэсний аюулгүй байдал нь стратегийн үндэсний тэргүүлэх зорилтын хүрээнд дэвшүүлсэн зорилго зорилтыг биелүүлснээр хангагдана.

Оросын ард түмнийг аварч, хүний чадавхыг хөгжүүлэх

28. Ард түмэн бол ОХУ-ын бүрэн эрхт байдал, түүний үндсэн баялаг хөрөнгийг эзэмшигч юм. Оросын оюун санааны болон ёс суртахууны үзэл санаа, соёл, түүхийн үнэт зүйлс, ард түмний авьяас чадвар нь төрт ёсны үндэс бөгөөд улс орны цаашдын хөгжлийн суурь юм.

29. ОХУ-д хэрэгжиж буй төрийн нийгэм, эдийн засгийн бодлого нь хүний зохистой амьдрал, чөлөөт хөгжлийг хангах, иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, нас баралтыг бууруулах, орон сууцны нөхцөлийг сайжруулах, чанартай боловсрол эзэмших боломжуудыг өргөжүүлэхэд чиглэгдэнэ.

30. Гэр бүл, эх, эцэг, хүүхэд нас, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настан, хүүхдийн хүмүүжил, тэдний оюун санаа, ёс суртахуун, бие бялдрын бүх талын хөгжлийг дэмжихэд онцгой анхаарал хандуулна. Ахмад үеийнхний зохистой амьдрах нөхцөл идэвхтэй бүрдэж байна. Төрөлтийн түвшинг нэмэгдүүлэх нь Оросын хүн амыг нэмэгдүүлэх урьдчилсан нөхцөл болж байна.

31. Хүний чадавхыг цаашид хөгжүүлэх явдал нь Оросын иргэдийн орлого, сайн сайхан байдлыг тогтвортой өсгөх, тав тухтай, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх,

эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуй, халдвар судлалын сайн сайхан байдал, нийгмийн хамгаалал, боловсрол, соёлын чиглэлээр үндсэн хуулиар олгогдсон эрхийг баталгаатай болзолгүйгээр хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдээр хангагдах ёстой.

32. ОХУ-ын ард түмнийг аврах, хүний чадавхыг хөгжүүлэх төрийн бодлогын зорилго нь хүн амын байгалийн тогтвортой өсөлт, хүн амын амьдралын чанарыг сайжруулах, иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, ядуурлыг бууруулах, нийгмийн болон өмч хөрөнгийг тэгш бус байдлыг бууруулах, хүн амын боловсролын түвшинг дээшлүүлэх, эв нэгдэлтэй, нийгмийн хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх явдал юм.

33. ОХУ-ын ард түмнийг аврах, хүний чадавхыг хөгжүүлэх чиглэлээр төрийн бодлогын зорилгод хүрэх явдал нь дараах зорилтыг шийдвэрлэх замаар хангагдана.

1) Хүн амын бодит орлогыг нэмэгдүүлэх, бага орлоготой иргэдийн тоог бууруулах, тэдний орлогоос хамааран иргэдийн тэгш бус байдлын түвшин бууруулах;

2) Нийгмийн үйлчилгээний чанар, бүх иргэдэд хүртээмжтэй байдлыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настнуудын нийгмийн амьдралд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх;

3) Төрөлт нэмэгдэх, олон хүүхэдтэй болох хүсэл эрмэлзлийг бий болгох;

4) Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, нас баралт, хөгжлийн бэрхшээлийн түвшинг бууруулах, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх;

5) Эмнэлгийн тусламж, түүний дотор вакцинжуулалт, эмийн хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулах;

6) Эрүүл мэндийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах, түүнийг шинэ сорилт, аюулд дасан зохицуулах, түүний дотор халдварт өвчний тархалт, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх;

7) Иргэдийн эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх сэдлийг нэмэгдүүлэх;

8) Биологийн аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зорилгоор биологийн эрсдэлийн хяналтын тогтолцоог хөгжүүлэх;

9) Хүн амын эрүүл ахуй, эпидемиологийн сайн сайхан байдлыг хангах, нийгэм, эрүүл ахуйн хяналтын тогтолцоог хөгжүүлэх;

10) Аюулгүй, өндөр чанартай хүнсний бүтээгдэхүүний бодит, эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлэх;

11) Хүүхэд, залуучуудын чадвар, авьяас чадварыг тодорхойлох, хөгжүүлэх;

12) Ерөнхий боловсролын чанарыг сайжруулах;

13) Иргэдийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн насан туршдаа дунд болон дээд мэргэжлийн боловсрол эзэмших, мэргэжлийн боловсрол олгох, давтан сургах өргөн боломжоор хангах;

14) Оросын уламжлалт оюун санаа, ёс суртахуун, соёл, түүхийн үнэт зүйлсийн үндсэн дээр хүүхэд, залуучуудын боловсрол, хүмүүжилийг бий болгох;

15) Соёлын салбарыг хөгжүүлэх, иргэдийн соёлын ашиг тусын хүртээмжийг нэмэгдүүлэх;

16) Иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцны хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, орон сууц, нийтийн аж ахуйн дэд бүтцийг хөгжүүлэх;

17) бүх суурин газруудад тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, тэдгээрийн тээвэр, эрчим хүчний дэд бүтцийг хөгжүүлэх.

Улс орны батлан хамгаалалт

34. Дэлхийн цэрэг-улс төрийн нөхцөл байдал нь дэлхийн болон бүс нутгийн хүчний шинэ төвүүд үүсэж, тэдгээрийн хоорондын нөлөөллийн хүрээний төлөөх тэмцэл эрчимжиж байгаагаараа онцлог юм. Олон улсын харилцааны субъектуудын геополитикийн зорилгодоо хүрэх хэрэгсэл болох цэргийн хүчний ач холбогдол улам бүр нэмэгдсээр байна.

35. ОХУ, түүний холбоотнууд болон түншүүдэд дарамт шахалт үзүүлэх, Хойд Атлантын эвслийн байгууллагын цэргийн дэд бүтцийг Оросын хилийн ойролцоо бий болгох, тагнуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх, ОХУ-ын эсрэг томоохон цэргийн ангиуд, цөмийн зэвсэг ашиглах дадлага хийх оролдлого нь ОХУ-д цэргийн аюул, заналхийллийг бий болгож байна.

36. Дэлхийн пуужингийн довтолгооноос хамгаалах системийн чадавхыг хөгжүүлж буйтай холбогдуулан Америкийн Нэгдсэн Улс (АНУ) зэвсгийн хяналтын чиглэлээр олон улсын үүргээсээ татгалзах тууштай бодлого баримталж байна. АНУ-ын дунд болон богино зайн тусгалтай пуужингуудыг Европ болон Ази, Номхон далайн бүс нутагт байрлуулахаар төлөвлөж байгаа нь стратегийн тогтвортой байдал, олон улсын аюулгүй байдалд заналхийлж байна.

37. ЗХУ-ын дараах орон зай, Ойрх Дорнод, Хойд Африк, Афганистан, Солонгосын хойгийн мөргөлдөөнтэй бүс нутагт хурцадмал байдал нэмэгдсээр байна. Дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын тогтолцоо суларч байгаа нь олон улсын терроризм, экстремизм тархах нөхцөлийг бүрдүүлж байна.

38. ОХУ-ын зэвсэгт хамгаалалт, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, халдашгүй дархан байдлыг хангахад бэлтгэх зорилгоор улс орныг батлан хамгаалах ажлыг зохион байгуулдаг.

39. Улс орны батлан хамгаалахын зорилго нь ОХУ-ын нийгэм, эдийн засгийг тайван замаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, цэргийн аюулгүй байдлыг хангах явдал юм.

40. Цэргийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд улс орны батлан хамгаалахын зорилт нь цэргийн мөргөлдөөнийг стратегийн тогтоон барилтаар таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, төрийн цэргийн байгуулалт, Зэвсэгт хүчнийг ашиглах аргахэлбэр, үйл ажиллагааг боловсронгуй болгох ОХУ-ын Зэвсэгт хүчин (цаашид Зэвсэгт хүчин гэх), бусад цэрэг, цэргийн анги, байгууллагын дайчилгааны бэлэн байдал, иргэний хамгаалалтын хүч, хэрэгслийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх замаар явагдана. Үүний зэрэгцээ дараах асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарал хандуулж байна.

1) Одоо байгаа болон болзошгүй цэргийн аюул, заналхийллийг цаг тухайд нь тодорхойлох;

2) ОХУ-ын цэргийн төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгох, Оросын эсрэг цэргийн хүч хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, түүний бүрэн эрх бүрэн бүтэн байдал, нутаг дэвсгэрийг хамгаалахад чиглэсэн харилцан уялдаатай улс төр, цэрэг, цэрэг-техник, дипломат, эдийн засаг, мэдээллийн болон бусад арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх;

3) Цөмийн зэвсгээс урьдчилан сэргийлэх чадавхыг хангалттай түвшинд байлгах;

4) Зэвсэгт хүчин, бусад цэрэг, цэргийн анги, байгууллагын байлдааны бэлэн байдлын тодорхой түвшинг хангах;

5) Нутаг дэвсгэрээс гадуурх ОХУ-ын үндэсний ашиг сонирхол, иргэдийг хамгаалах;

6) цэргийн байгууллагын бүрэлдэхүүн хэсгүүдийг тэнцвэртэй хөгжүүлэх, батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх, Зэвсэгт хүчин, бусад цэрэг, цэргийн анги, байгууллагуудыг орчин үеийн зэвсэг, техник, тусгай хэрэгслээр хангах;

7) ОХУ-д дайчилгааны бэлтгэл, дайчилгааг хангах арга хэмжээний төлөвлөлтийг боловсронгуй болгох, тэдгээрийг шаардлагатай хэмжээнд хэрэгжүүлэх, улсын цэргийн байгууллагын цэрэг-техникийн чадавхыг цаг тухайд нь шинэчлэх, хангалттай түвшинд байлгах;

8) Орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний мөн чанарын өөрчлөлтийн чиг хандлагыг цаг тухайд нь авч үзэх, цэргийн хүчний байлдааны чадварыг хамгийн бүрэн дүүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, ирээдүйн цэргийн бүрэлдэхүүн, зэвсэгт тэмцлийн шинэ хэрэгсэлд тавигдах шаардлагыг боловсруулах;

9) ОХУ-ын цэрэг-аж үйлдвэрийн цогцолборын технологийн бие даасан байдлыг хангах, түүний шинэлэг хөгжил, зэвсэг, цэргийн болон тусгай хэрэгслийн шинэ ирээдүйтэй загвар, цогцолбор, системийг боловсруулах, үйлдвэрлэх, манлайллыг хадгалах;

10) ОХУ-ын эдийн засаг, түүнийг бүрдүүлэгч аж ахуйн нэгжүүдийн эдийн засаг, хотын захиргаадын эдийн засгийг бэлтгэх, төрийг зэвсэгт халдлагаас хамгаалах, дайны үеийн улсын хэрэгцээ, хүн амын хэрэгцээг хангахад төрийн эрх мэдэл, орон нутгийн засаг захиргаа, байгууллага, Зэвсэгт хүчин, бусад цэрэг, цэргийн анги, байгууллагыг бэлтгэх;

11) ОХУ-ын нутаг дэвсгэрт байгаа хүн ам, материаллаг болон соёлын үнэт зүйлийг цэргийн мөргөлдөөн эсвэл эдгээр мөргөлдөөний үр дүнд бий болох аюулаас хамгаалах, хамгаалахад шаардлагатай бэлтгэл ажлыг хангах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

12) Зэвсэгт хүчин, бусад цэрэг, цэргийн анги, байгууллага дахь боловсон хүчний ёс суртахуун, улс төр, сэтгэл зүйн байдал, хууль тогтоомж, цэргийн сахилга батыг өндөр түвшинд байлгах;

13) Иргэдийг цэрэг-эх оронч боловсрол, цэргийн албанд бэлтгэх;

14) Цэргийн албан хаагчид, тэдний гэр бүлийн гишүүд, цэргийн албанаас халагдсан иргэдийн нийгмийн хамгааллын түвшинг нэмэгдүүлэх, түүнчлэн цэргийн алба хаах нөхцөлийг сайжруулах.

Төрийн болон олон нийтийн аюулгүй байдал

41. Хүн, эд хөрөнгийн аюулгүй байдлын баталгаа болох төрийн үүргийг бэхжүүлэх,

хууль сахиулах байгууллага, тусгай албаны үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх нь төрийн болон олон нийтийн аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулдаг. ОХУ-ын үндсэн хуулийн дэг журам, хүн, иргэний эрх, эрх чөлөөг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төрийн нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох, гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд шийтгэл оногдуулах зайлшгүй байх зарчмыг хэрэгжүүлэх, түүнчлэн хууль бус үйлдлийг үл тэвчих уур амьсгал нийгэмд төлөвшүүлэх нь төрийн болон олон нийтийн аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулдаг.

42. Авсан арга хэмжээнүүдийг үл харгалзан ОХУ-д тодорхой газар нутагт гэмт хэргийн түвшин өндөр хэвээр байна. Өмчийн эсрэг гэмт хэрэг, усны биологийн болон ойн нөөцийг ашиглах, орон сууц, нийтийн аж ахуй, зээл, санхүүгийн салбарт олон тооны гэмт хэрэг үйлдэгддэг. Мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн тоо өссөөр байна. Хэт даврагч үзлийн илрэл нь нийгэм-улс төрийн байдлыг тогтворгүйжүүлэх нөлөө үзүүлж байна.

43. Уур амьсгалын өөрчлөлт, ой хээрийн түймэр, үер, инженерийн болон тээврийн дэд бүтцийн элэгдэл, аюултай халдварт өвчний тархалт зэрэг байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшгийн аюул заналхийлэл хэвээр байна.

44. ОХУ-ын нутаг дэвсгэрт үүссэн нийгэм, эдийн засгийн объектив хүндрэлийг нийгмийн сөрөг үйл явцыг өдөөх, үндэстэн хоорондын болон шашин хоорондын мөргөлдөөнийг хурцатгах, мэдээллийн салбарт гуйвуулалт хийх зорилгоор гадаад болон дотоодод сүйтгэгч хүчнүүд ашиглахыг оролдож байна. Гадаад улсын тусгай алба, байгууллагуудын тагнуулын болон бусад үйл ажиллагаа нь Оросын олон нийтийн холбоо, тэдний хяналтад байдаг хувь хүмүүсийн оролцоотойгоор явагдаж байна. Олон улсын террорист, хэт даврагч байгууллагууд Оросын иргэдийг элсүүлэх, тэдний нууц үүрийг ОХУ-д бий болгох, орос залуучуудыг хууль бус үйл ажиллагаанд татан оролцуулах ажлыг эрчимжүүлэхийг хичээж байна. Дэлхийн интернэт компаниудыг худал мэдээлэл түгээх, хууль бус олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад өргөн ашиглаж байна.

45. ОХУ-д нийгэм, эдийн засагт тулгамдаж буй асуудлуудын дунд төрийн удирдлагын үр ашгийг дээшлүүлэх, нийгмийн шударга ёсыг хангах, авлига, төсвийн хөрөнгө, төрийн өмчийг зүй бусаар ашиглахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх шаардлага нийгэмд улам бүр нэмэгдэж байна. Төрийн эрх мэдэл, төрийн оролцоотой байгууллагад бүлгийн болон холбогдох ашиг сонирхлын нөлөөнд автахгүй боловсон хүчний бодлого явуулах шаардлагатай байна.

46. Төрийн болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилго нь ОХУ-ын үндсэн хуулийн дэг журмыг хамгаалах, түүний бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, төр, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах, хүн, иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах, иргэний энх тайван, эв найрамдлыг бэхжүүлэх, нийгэм дэх улс төр, нийгмийн тогтвортой байдлыг хангах, төр, иргэний нийгмийн харилцан үйлчлэлийн механизмыг сайжруулах, хууль, дэг журмыг бэхжүүлэх, авлигыг устгах, иргэд болон өмчийн бүх хэлбэр, Оросын уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлсийг хууль бус халдлагаас хамгаалах, байгалийн болон гар аргаар үүссэн гамшигт ослын үед хүн ам, нутаг дэвсгэрийг хамгаалах явдал юм.

47. Төрийн болон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгод хүрэх нь дараах

зорилтыг шийдвэрлэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар хэрэгжинэ.

1) ОХУ-ын үндсэн хуулийн дэг журам, хүн, иргэний эрх, эрх чөлөө, түүний дотор «өнгөт хувьсгал»-ыг өдөөх замаар ОХУ-ын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохоос урьдчилан сэргийлэх, тусгай алба, гадаад улсын байгууллага, түүнчлэн ОХУ-ын үндэсний ашиг сонирхлыг хохироож буй хувь хүмүүсийн тагнуулын болон бусад үйл ажиллагааг таслан зогсоох;

2) ОХУ-ын нутаг дэвсгэрт болж буй нийгэм, улс төрийн болон бусад арга хэмжээний аюулгүй байдлыг хангах;

3) ОХУ-ын улсын хилийн хамгаалалт, нутаг дэвсгэрийн тэнгисийн хамгаалалтыг хангах, ОХУ-ын эдийн засгийн онцгой бүс, эх газрын нутгийг хамгаалах, түүнчлэн хилийн дэд бүтцийг шинэчлэх, хилийн боомтын нэвтрүүлэх механизм, хил, гааль, ариун цэвэр-эпидемиологийн болон бусад төрлийн хяналтыг боловсронгуй болгох;

4) ОХУ-ын хууль сахиулах, шүүхийн тогтолцоонд иргэдийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, төрийн болон олон нийтийн аюулгүй байдлыг хангахад олон нийтийн хяналтын тогтолцоо, иргэд, байгууллагын оролцооны механизмыг боловсронгуй болгох;

5) Иргэний нийгмийн институцийг хөгжүүлэх, нийгмийн ач холбогдолтой санаачилгыг дэмжих, нийгмийн хурцадмал байдлыг нэмэгдүүлэхэд хүргэж болзошгүй асуудлыг шийдвэрлэхэд иргэний нийгмийн институци ба хүн амын төрийн эрх бүхий байгууллагатай харилцах харилцааг хөгжүүлэх;

6) Хүмүүсийн олноор оршин суудаг газар, хүн амын амьдралыг дэмжих байгууламж, цэрэг баглан хамгаалах аж үйлдвэрлэл, цөмийн эрчим хүчний үйлдвэр, цөмийн зэвсэг, химийн бодис, түлш, эрчим хүчний цогцолбор, дэд бүтцийн байгууламж, бусад чухал болон аюултай байгууламж, тээврийн хэрэгслийн терроризмын эсрэг хамгаалалтын түвшинг нэмэгдүүлэх;

7) Байгууллага, хувь хүмүүсийн террорист, хэт даврагч үйл ажиллагаа, цөмийн, химийн болон биологийн терроризмын үйлдэл хийх оролдлогоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;

8) Олон нийтийн харилцааны гэмт хэргийн түвшинг бууруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төрийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх;

9) Радикализмын илрэлээс урьдчилан сэргийлэх, ялангуяа насанд хүрээгүй, залуучуудын дунд хэт даврагч болон бусад гэмт хэргийн шинж тэмдгүүдээс урьдчилан сэргийлэх;

10) Эдийн засгийн салбарт, түүний дотор зээл, санхүүгийн салбарт гэмт хэргийн түвшинг бууруулах, түүнчлэн орон сууц, нийтийн аж ахуй, газар, ой, ус, усны биологийн нөөцийг ашиглахтай холбоотой гэмт хэргийн түвшинг бууруулах;

11) Мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан үйлдэгдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүний дотор эрүүгийн орлогыг хууль ёсны болгох, терроризмыг санхүүжүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар түгээх ажлыг зохион байгуулах, түүнчлэн хууль бус дижитал валют хэрэглээний гэмт хэргээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох ;

12) Гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө шийтгэл зайлшгүй хүлээж байх зарчмыг хэрэгжүүлэх;

13) Төрийн байгууллага, төрийн оролцоотой байгууллагад, тэр дундаа үндэсний төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, улсын батлан хамгаалах даалгаврыг хэрэгжүүлэхэд, авлига төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах, завших гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүнчлэн учирсан хохирлыг барагдуулах, энэ төрлийн гэмт хэргийн улмаас үүссэн, үйлдсэн хариуцлагын түвшинг нэмэгдүүлэх;

14) Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, улс орны хөгжлийн нийгмийн ач холбогдолтой үр дүнд хүрэхгүй байх шалтгаан болсон үйлдэлдүүрэх албан тушаалтнуудын хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох;

15) Зэвсэг, сум, тэсэрч дэлбэрэх бодис, түүнчлэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн дагалдах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох;

16) Хууль бус шилжилт хөдөлгөөнтэй тэмцэх, шилжилт хөдөлгөөний урсгалд тавих хяналтыг бэхжүүлэх, цагаачдын нийгэм, соёлын дасан зохицох, тэгш байдлыг сайжруулах;

17) Нийгэм, шашин хоорондын болон үндэстэн хоорондын мөргөлдөөн, салан тусгаарлах үзлээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах, шашны радикализм, шашны хорлон сүйтгэх хөдөлгөөн тархахаас урьдчилан сэргийлэх, угсаатны болон шашны бүс нутгууд, иргэд зарим бүлгүүдийн нийгэм, угсаатны соёлын тусгаарлалт үүсэхээс урьдчилан сэргийлэх;

18) Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах;

19) Байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, арилгах арга хэмжээний үр нөлөөг нэмэгдүүлэх;

20) Хүн амын ариун цэврийн болон эпидемиологийн сайн сайхан байдлын чиглэлээр гамшиг осол үүсгэж болзошгүй аюултай халдварт өвчнөөс хүн амыг хамгаалах;

21) Аюултай үйлдвэрлэлийн байгууламж, гидротехникийн байгууламж, тээврийн цогцолбор, хүн амын амьдралыг дэмжих байгууламжийн төлөв байдалд уур амьсгалын өөрчлөлтийн үр дагаврын нөлөөллийг урьдчилан таамаглах;

22) Хууль сахиулах байгууллага, тусгай алба, гал түймэр унтраах анги, аврах ангиудыг зорилго зорилтынх нь дагуу иж бүрэн хөгжүүлэх, техникийн хангамжийн түвшинг нэмэгдүүлэх, ажилтнуудын нийгмийн хамгааллыг бэхжүүлэх, ажилтнуудын мэргэжлийн сургалтын тогтолцоог боловсронгуй болгож төрийн болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх;

23) ОХУ-ын иргэн, хуулийн этгээдийг гадаадын болон олон улсын (улс хоорондын) шүүхийн улс төрийн өрөөсгөл шийдвэрээс хамгаалах хууль ёсны хамгаалалтаар хангах.

Мэдээллийн аюулгүй байдал

48. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хурдацтай хөгжлийг дагаад иргэд, нийгэм, төрийн аюулгүй байдалд заналхийлэх магадлал нэмэгдсээр байна.

49. Улс орнуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох, тусгаар тогтнолыг алдагдуулах, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд нь халдах зорилгоор мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглах явдал нэмэгдэж байгаа нь олонулсын энх тайван, аюулгүй байдалд заналхийлж байна.

50. Оросын мэдээллийн нөөц дэх компьютерын халдлагын тоо нэмэгдэж байна. Эдгээр халдлагын ихэнх нь гадаадын улс орны нутаг дэвсгэрээс үйлдэгдэж байна. Олон улсын мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ОХУ-ын санаачилга дэлхийн мэдээллийн орон зайд ноёрхохыг эрмэлзэж буй гадаадын улс орнуудын эсэргүүцэлтэй тулгарч байна.

51. Оросын мэдээллийн орон зайд тагнуулын болон бусад ажиллагаа явуулах гадаад улсын тусгай албадын үйл ажиллагаа эрчимжиж байна. Ийм улсуудын зэвсэгт хүчин ОХУ-ын мэдээллийн чухал дэд бүтцийг идэвхгүй болгох арга хэмжээ авч байна.

52. ОХУ-ын нийгэм-улс төрийн байдлыг тогтворгүй болгохын тулд террорист үйлдэл хийх аюулын тухай зориудаар худал мэдээлэл тарааж байна. Мэдээлэл, харилцаа холбооны «Интернэт» сүлжээ (цаашид Интернэт) нь террорист болон хэт даврагч байгууллагуудын материалыг агуулсан, олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, хэт даврагч үйл ажиллагаа явуулах, тогтоосон дэг журмыг зөрчиж зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд оролцох, гэмт хэрэг үйлдэх, амиа хорлох мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх, хууль бус мэдээллийг байршуулах зэрэг гэмт хэргийн шинжтэй амьдралын хэв маягийг сурталчилж байна. Ийм хор хөнөөлтэй нөлөөний гол объект нь залуучууд болж байна.

53. Үндэстэн дамнасан корпорацуудын интернэт дэх монополь байр сууриа нэгтгэх, мэдээллийн бүх нөөцийг хянах хүсэл эрмэлзэл нь эдгээр корпорациудын (хуулийн үндэслэл байхгүй, олон улсын хууль тогтоомжид харшлах) цензур тавих, өөр интернэт платформыг хаах явдал юм. Улс төрийн шалтгаанаар интернэтийн хэрэглэгчид түүхэн баримт, түүнчлэн ОХУ-д болон дэлхий дахинд болж буй үйл явдлуудыг гажуудуулсан байдлаар харахаас өөр аргагүй байдалд оруулж байна.

54. Мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан нэрээ нууцлах нь гэмт хэрэг үйлдэхэд дөхөм болж, гэмт хэрэг үйлдэж олсон орлого нь терроризмыг санхүүжүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тараах зэргээр гэмт хэргийг хууль ёсны болгох боломжийг өргөжүүлж байна.

55. ОХУ-ын нутаг дэвсгэрт гадаадын мэдээллийн технологи, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг ашиглах нь Оросын мэдээллийн нөөц, түүний дотор ОХУ-ын мэдээллийн чухал дэд бүтцэд гадаадаас үзүүлэх нөлөөллийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.

56. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилго нь мэдээллийн орон зайд ОХУ-ын бүрэн эрхт байдлыг бэхжүүлэх явдал юм.

57. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгод хүрэх нь дараах зорилтыг шийдвэрлэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар хэрэгжинэ.

1) Найдвартай мэдээллийн эргэлтийн аюулгүй орчныг бүрдүүлэх, ОХУ-ын мэдээллийн дэд бүтцийн аюулгүй байдал, түүний үйл ажиллагааны тогтвортой байдлыг нэмэгдүүлэх;

2) ОХУ-ын мэдээллийн аюулгүй байдалд заналхийлж буй аюулыг урьдчилан

таамаглах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх, тэдгээрийн эх үүсвэрийг тодорхойлох, эдгээр аюул заналхийллийн үр дагаврыг нэн даруй арилгах тогтолцоог хөгжүүлэх;

3) Оросын мэдээллийн нөөц, түүний дотор ОХУ-ын мэдээллийн чухал дэд бүтцийн объектуудад хор хөнөөлтэй мэдээлэл, техникийн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх;

4) Мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, таслан зогсоох нөхцөлийг бүрдүүлэх;

5) ОХУ-ын харилцаа холбооны нэгдсэн сүлжээ, интернэтийн Оросын сегмент, мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн бусад чухал объектуудын аюулгүй байдал, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, түүнчлэн тэдгээрийн үйл ажиллагаанд тавих гадаадын хяналтаас урьдчилан сэргийлэх;

6) Хязгаарлагдмал мэдээлэл, хувийн мэдээллийн задралтын тоог хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулах, түүнчлэн ийм мэдээлэл, хувийн мэдээллийг хамгаалахад ОХУ-ын хууль тогтоомжоор тогтоосон шаардлагыг зөрчих тоог бууруулах;

7) Гадаад улсын техникийн тагнуулын үйл ажиллагаатай холбоотой үндэсний аюулгүй байдалд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, (эсвэл) багасгах;

8) Хувийн мэдээллийг боловсруулах, түүний дотор мэдээллийн технологийг ашиглан хүн, иргэний үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хамгаалах;

9) Зэвсэгт хүчин, бусад цэрэг, цэргийн анги, байгууллага, түүнчлэн зэвсэг, цэргийн болон тусгай хэрэгсэл үйлдвэрлэгчдийн мэдээллийн аюулгүй байдлыг бэхжүүлэх;

10) Мэдээллийн сөргөлдөөний хүч, хэрэгслийг хөгжүүлэх;

11) ОХУ-ын мэдээллийн дэд бүтцийг хэт даврагч, террорист байгууллага, гадаад улсын тусгай алба, суртал ухуулгын байгууллагуудын зүгээс иргэд, нийгэмд хор хөнөөлтэй мэдээллийн нөлөө үзүүлэх зорилгоор ашиглах явдалтай тэмцэх;

12) Дэвшилтэт технологи, түүний дотор хиймэл оюун ухааны технологи, квант тооцоолол ашиглахад суурилсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг боловсронгуй болгох;

13) ОХУ-ын мэдээллийн дэд бүтцэд мэдээллийн аюулгүй байдлын шаардлагад нийцсэн ОХУ-ын мэдээллийн технологи, тоног төхөөрөмжийг нэн тэргүүнд ашиглах, түүний дотор үндэсний төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, төрийн захиргаа эдийн засгийг дижиталжуулах чиглэлээр тулгарч буй асуудлыг шийдвэрлэх;

14) Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр, түүний дотор мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглах чиглэлээр аюулгүй байдлыг хангах олон улсын эрх зүйн дэглэмийг бий болгох зорилгоор ОХУ-ын гадаад түншүүдтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх;

15) ОХУ-ын дотоод, гадаад бодлогын талаарх найдвартай мэдээллийг Орос, олон улсын нийтэд хүргэх;

16) ОХУ-ын мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулахад төрийн эрх мэдэл, иргэний нийгмийн институци, байгууллагуудын хоорондын харилцааг хөгжүүлэх.

Эдийн засгийн аюулгүй байдал

58. Дэлхийн эдийн засаг гүн хямралд байна. Зах зээлийн тогтворгүй байдал, олон улсын санхүүгийн системийн тогтворгүй байдал нэмэгдэж, бодит болон цахим эдийн засгийн ялгаа улам бүр нэмэгдсээр байна. Дэлхийн улс орон, бүс нутгийн эдийн засгийн өндөр харилцан хамаарлыг хадгалахын зэрэгцээ олон улсын шинэ үйлдвэрлэлийн сүлжээ, нийлүүлэлтийн сүлжээ үүсэх үйл явц удааширч, хөрөнгө оруулалтын урсгал буурч байна. Худалдаа, эдийн засгийн салбарт үндэсний улс орнууд, бүс нутгийн хэлэлцээрүүдийн үүрэг нэмэгдэж байна.

59. Тогтвортой хөгжилд шилжихэд нийгэм-эдийн засгийн хуримтлагдсан асуудлууд, улс орнуудын хөгжлийн тэнцвэргүй байдал, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэхийн тулд өмнө нь хэрэглэж байсан хэрэгслүүд үр дүнгүй байгаа зэрэг нь саад болж байна. Олон улсын эдийн засгийн харилцааг зохицуулах тогтолцоо суларч, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлыг улстөржүүлж, улс орнуудын харилцан итгэлцэлгүй байдал, хязгаарлалтын арга хэмжээ (хориг), протекционизмын өсөлт, нэг талын хэрэглээ зэргээс шалтгаалан дэлхийн эдийн засгийн хэтийн төлөвийн тодорхойгүй байдал нэмэгдэж байна.

60. Дэлхийн эдийн засагт хийгдэж буй бүтцийн өөрчлөлт, түүний хөгжлийн технологийн суурь өөрчлөлттэй холбоотойгоор хүний нөөц, байгаль орчны асуудал улам бүр чухал болж байна. Бараа, хөрөнгө, технологи, хөдөлмөрийн уламжлалт зах зээлийн өөрчлөлт, эдийн засгийн шинэ салбарууд үүсэх нь дэлхийн улс орон, бүс нутгийн үүрэг, чадавхыг дахин хуваарилах, эдийн засгийн нөлөөллийн шинэ төвүүдийг бий болгох байдал дагалдаж байна.

61. Өргөн уудам нутаг дэвсгэр, газар зүйн таатай байрлал, байгаль цаг уурын олон янзын нөхцөл, ашигт малтмалын нөөц, шинжлэх ухаан, технологи, боловсролын чадавх, макро эдийн засгийн тогтвортой байдал, дотоодын улс төрийн тогтвортой байдал, үндэсний батлан хамгаалах, төрийн аюулгүй байдлын өндөр түвшин зэрэг нь Оросын эдийн засгийг шинэчлэх нөхцөл, Оросын аж үйлдвэрийн чадавхыг хөгжүүлэх нэн таатай нөхцөлийг бүрдүүлдэг хүчин зүйлүүд юм.

62. Анхдагч түүхий эд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг экспортлохоос гүн боловсруулахад шилжих, одоо байгаа үйлдвэрүүдийг хөгжүүлэх, шинэ өндөр технологийн үйлдвэрлэл, зах зээлийг бий болгохын зэрэгцээ эдийн засгийн суурь салбаруудад технологийн шинэчлэл, нүүрстөрөгч багатай технологиуд нэвтрүүлэх нь Оросын эдийн засгийн бүтцэд өөрчлөлт оруулж, өрсөлдөх чадвар, тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд хүргэнэ.

63. ОХУ-ын шинжлэх ухаан, техник, үйлдвэрлэл, нөөцийн чадавхыг нэгтгэх, дотоодын зах зээлийг Оросын үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээр дүүргэх, шинжлэх ухааны шинэ дэвшилтэт технологи бий болоход хувь нэмэр оруулах томоохон хөрөнгө оруулалтыг татаж, инновацийн хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх нь ОХУ-ын урт хугацааны эдийн засгийн хөгжил, үндэсний аюулгүй байдлыг цаашид бэхжүүлэх үндэс суурийг бүрдүүлнэ.

64. ОХУ-ын эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ОХУ-ын эдийн засаг, нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэргүй байдлыг арилгах, дэд бүтцийн бэрхшээлийг даван туулах, бие даасан санхүү, банкны тогтолцоог бүрдүүлэх, шинэлэг үйл ажиллагааг хөгжүүлэх, ОХУ-ын эдийн засгийн хөгжлийн стратегийн

удирдлагын үр ашгийг дээшлүүлэх, өрсөлдөх давуу талыг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засгийн төрийн зохицуулалттай арга хэмжээнүүдийг авах шаардлагатай.

65. ОХУ-ын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах чухал нөхцөл бол улс орны дотоод чадавхад тулгуурлах, бусад улс орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагаанд нээлттэй байхын зэрэгцээ Оросын өмнө тулгарч буй зорилтуудыг бие даан шийдвэрлэх явдал юм. Дэлхийн хөгжлийн төвүүдтэй олон талт харилцаа холбоо тогтоох нь Оросын эдийн засгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх болно.

66. ОХУ-ын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилго нь улс орны эдийн засгийн тусгаар тогтнолыг бэхжүүлэх, Оросын эдийн засгийн өрсөлдөх чадвар, гадаад, дотоод аюулын нөлөөнд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх явдал бөгөөд Оросын Холбооны Улсын эдийн засгийн хөгжлийн хурд нь дэлхийнхээс өндөр байх болно.

67. ОХУ-ын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгод хүрэх нь дараах зорилтыг шийдвэрлэх замаар явагдана.

1) Орчин үеийн технологийн үндсэн дээр үндэсний эдийн засгийн бүтэц, бүтцийн өөрчлөлтийг хангах, нүүрстөрөгчийн хий багатай технологи ашиглах үндсэн дээр төрөлжүүлэн хөгжүүлэх;

2) Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, инфляцийг тогтмол бага түвшинд байлгах, рублийн тогтвортой байдал, төсвийн системийн тэнцвэрт байдлыг хангах;

3) Бараа, үйлчилгээний төлбөрийн чадвартай дотоодын эрэлтийг нэмэгдүүлэх, иргэдэд олгох зээлийн өсөлтийг тэнцвэржүүлэх, өрийн дарамт нэмэгдэхтэй холбоотой эрсдэлийг хязгаарлах;

4) Үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалтын өсөлтийн хурдацыг нэмэгдүүлэх, урт хугацааны зээлийн олноц, хөрөнгө оруулалтыг хамгаалах, дэмжих, хөрөнгө оруулалтын дотоод эх үүсвэрийн ашиглалтыг идэвхжүүлэх;

5) Эдийн засгийн бодит секторын тогтвортой хөгжлийг хангах, өндөр технологийн үйлдвэрлэл, эдийн засгийн шинэ салбар, ирээдүйтэй өндөр технологид суурилсан бараа, үйлчилгээний зах зээлийг бий болгох;

6) Аж үйлдвэр, аж ахуйн нэгж, дэд бүтцийг шинэчлэх, цахимжуулах, хиймэл оюун ухааны технологийг ашиглах, өндөр технологийн ажлын байр бий болгох замаар хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх;

7) Оросын технологийн дэвшилтэт хөгжлийг хурдасгах, үйлдвэрлэлийг Орост нутагшуулах замаар Оросын эдийн засгийн технологи, тоног төхөөрөмж, эд ангиудын импортоос ихээхэн хамааралтай байдлыг даван туулах;

8) ОХУ-ын нисэх, усан онгоц, пуужин, сансрын үйлдвэрлэл, хөдөлгүүрийн үйлдвэрлэл, цөмийн эрчим хүчний үйлдвэрлэл, түүнчлэн мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт олж авсан тэргүүлэх байр суурь, өрсөлдөх давуу талаа бэхжүүлэх;

9) Эдийн засгийн үндсэн салбарууд болох аж үйлдвэр, барилга, харилцаа холбоо, эрчим хүч, хөдөө аж ахуй, уул уурхайд технологийн эрчимтэй шинэчлэлт хийх, Оросын

инженерчлэл, түүний дотор багаж хэрэгсэл, машин механизмыг эрчимтэй хөгжүүлэх, дотоодын бүтээгдэхүүнийг нэн тэргүүнд ашиглаж эдийн засгийг шинэчлэх;

10) Радиоэлектроникийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эдийн засаг, төрийн удирдлагын дигиталжуулах чиглэлээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийн технологи, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг нэвтрүүлэх;

11) Цэрэг-аж үйлдвэрийн цогцолборын байгууллагуудын үйлдвэрлэлийн баазыг шинэчлэх, тэдгээрийн үйлдвэрлэсэн өндөр технологийн иргэний болон давхар хэрэглээний бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх;

12) Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх;

13) Тулгамдсан халдварт өвчний эсрэг дотоодын вакциныг боловсруулах, үйлдвэрлэх;

14) Үржлийн, селекцийн, үрийн аж ахуй, загасны аж ахуйн салбарт импортын эрсдэлтэй хамаарлыг даван туулах;

15) ОХУ-ын эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, түүний дотор хүн ам, үндэсний эдийн засгийн субъектуудыг дулаан, эрчим хүчээр тогтвортой хангах, эдийн засгийн эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, түлш, эрчим хүчний цогцолбор дахь төрийн удирдлагын үр ашгийг нэмэгдүүлэх;

16) сэргээгдэх болон өөр эрчим хүчний эх үүсвэрээс цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх технологийг хөгжүүлэх, нүүрстөрөгч багатай эрчим хүчийг хөгжүүлэх;

17) ОХУ-ын санхүүгийн систем, түүний бүрэн эрхт байдлыг бэхжүүлэх, санхүүгийн зах зээлийн үндэсний дэд бүтцийг, түүний дотор төлбөрийн дэд бүтцийг хөгжүүлэх, энэ чиглэлээр гуравдагч орноос хараат байдлыг арилгах, гадаадын түншүүдтэй үндэсний мөнгөн тэмдэгтээр төлбөр тооцоо хийх практикийг өргөжүүлэх, санхүүгийн хөрөнгийг гадаадад гаргах, хууль бус санхүүгийн гүйлгээтэй тэмцэх;

18) Гадаад эдийн засгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ам.долларын хэрэглээг бууруулах;

19) Оросын эдийн засгийн өсөлтийг хурдасгах зорилгоор зах зээл, эрчим хүч, инженерчлэл, инноваци, нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх;

20) Улс орны тээврийн үр ашигтай дэд бүтэц, тээврийн холболтыг хөгжүүлэх;

21) ОХУ-ын эдийн засгийн орон зайн нэгдмэл байдлыг бэхжүүлэх, ОХУ-ын бүрэлдэхүүн холбооны субъектуудын хамтын ажиллагаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх;

22) ОХУ-ын холбооны субъектуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, хурдац, амьдралын чанарын ялгааг багасгах, бүс нутгийн эдийн засгийн чадавхыг хөгжүүлэх, төсвийн аюулгүй байдлыг бэхжүүлэх;

23) ОХУ-ын эдийн засгийн аюулгүй байдалд учирч болзошгүй гадаад, дотоод сорилт, аюулыг харгалзан стратеги төлөвлөлтийн тогтолцоог хөгжүүлэх, эрсдэлд суурилсан хандлагыг нэвтрүүлэх замаар төрийн макро эдийн засгийн бодлогын үр ашгийг дээшлүүлэх;

24) Эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр төрийн хяналтын тогтолцоог

боловсронгуй болгох;

25) ОХУ-ын нутаг дэвсгэрт хөдөлмөрийн бүтээмжтэй хүчийг нүүлгэн шилжүүлэх, хуваарилах тогтолцоог боловсронгуй болгох, аж ахуйн нэгж, хүн амыг нийслэлийн бөөгнөрөлүүдэд төвлөрүүлэх хандлагыг даван туулах, түүнчлэн хөдөө орон нутагт болон жижиг, дунд хотуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах;

26) ОХУ-ын нутаг дэвсгэрт бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, Оросын болон гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд Оросын харьяаллын сонирхлыг нэмэгдүүлэх, эдийн засгийг оффшор болгох;

27) Төр, бизнесийн харилцан үйлчлэлийн механизмыг боловсронгуй болгох, жижиг, дунд бизнесийг ялангуяа үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн салбарт хөгжүүлэх;

28) Хөдөлмөрийн зах зээл дэх тэнцвэргүй байдал, инженер, ажилчдын хомсдолыг арилгах, албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах, хөдөлмөрийн харилцааг хуульчлах, мэргэжилтнүүдийн мэргэжлийн сургалтын түвшинг дээшлүүлэх, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн тэргүүлэх зарчмыг бий болгох;

29) Үйлдвэрлэлийн үйл явцыг автоматжуулахтай холбогдуулан чөлөөлөгдсөн ажилчдыг, түүний дотор нэг үйлдвэрийн нэг хотод амьдардаг хүмүүсийг хөдөлмөрийн харилцаанд шинээр татан оролцуулах;

30) Эдийн засгийн далд болон гэмт хэргийн салбарын эзлэх хувь, түүнчлэн бизнесийн орчин дахь авлигын түвшинг бууруулах;

31) Оросын зах зээл дэх өрсөлдөөнийг дэмжих, хөгжүүлэх, хамгаалах, монополь үйл ажиллагаа, шударга бус өрсөлдөөнийг таслан зогсоох, ОХУ-ын нутаг дэвсгэрт эдийн засгийн үйл ажиллагааны тэгш нөхцөл, эрх чөлөөг хангах;

32) Төсвийн хөрөнгийг ашиглах, төрийн өмчийн хөрөнгийг удирдах явдлын үр ашгийг нэмэгдүүлэх, стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгж, бусад байгууллагын өмч, түүний дотор хувьцааны хэсгийг ОХУ-ын өмчлөлд байлгах;

33) Оросын эдийн засгийн стратегийн чухал салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтад тавих хяналтыг бэхжүүлэх;

34) ОХУ-ын дайчилгааны хэрэгцээ, урт хугацаанд улс орны эдийн засгийн хэрэгцээг хангахад шаардлагатай ашигт малтмалын стратегийн нөөцийг бий болгох;

35) Олон улсын бизнесийн харилцаа холбоог хөгжүүлэх, Оросын бүтээгдэхүүний борлуулалтын зах зээлийг өргөжүүлэх, Оросын экспортын дэлхийн гол зах зээлийг зохицуулах гэсэн гадаадын улс орнуудын оролдлогын эсрэг тэмцэх.

Шинжлэх ухаан, технологийн хөгжил

68. Дэлхийн эдийн засаг технологийн шинэ суурьт шилжиж байгаа нөхцөлд шинжлэх ухаан, технологийн хөгжилд манлайлах нь өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн хүчин зүйлийн нэг болж байна. Шинжлэх ухаан, технологийн дэвшлийн хурдац нь хүний амьдралын бүхий л салбарт нөлөөлж, түүний амьдралын чанарт тусгагдсан байдаг.

69. Технологийн өөрчлөлт нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн өндөр хурдыг

бий болгох, төрийн болон компанийн үр дүнтэй засаглалыг хангахад инновацийн ач холбогдлыг нэмэгдүүлж байна.

70. Шинэ технологи нэвтрүүлэх нь үйлдвэрлэл, хэрэглээний механизмын өөрчлөлт, бараа, үйлчилгээний шинэ зах зээлийн үүсэлт, эдийн засгийн одоо байгаа салбаруудын дүр төрх, технологийн стандартын өөрчлөлт, байгалийн баялгийн боловсруулах түвшний нэмэгдэлт, дэлхийн эдийн засгийн эрчимжилтийн бууралтдагалдаж байна.

71. Шинэ мэргэжил гарч ирж, эрэлт хэрэгцээтэй болж, ажилчдын боловсрол, мэргэшлийн түвшин нэмэгдэж байна. Эрдэмтэн, өндөр мэргэшсэн мэргэжилтнүүдийг татах улс хоорондын өрсөлдөөн эрчимжиж байна.

72. Шинэ технологи бий болсноор өмнө нь хүрч чадаагүй шинж чанартай зэвсэг, цэргийн болон тусгай техник, хамгаалалтын системүүд бий болж байна. Улс орнуудын хоорондох эрх мэдлийн өрсөлдөөн шинэ орчинд шилжиж байна.

73. ОХУ-ын суурь болон хавсарга судалгааны чиглэлээрх өндөр чадавх, шинжлэх ухаан, боловсролын төвүүдийн өргөн хүрээтэй систем, олон тооны технологийн давуу талууд нь улс орны технологийн хурдацтай хөгжлийг хангах нөхцөлийг бүрдүүлдэг.

74. ОХУ-ын эдийн засгийн тогтвортой өсөлт, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, техник, инновацийн үйл ажиллагааг төрөөс дэмжих, ийм төрлийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд хувийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, тэдгээрийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх явцыг хурдасгах шаардлагатай.

75. ОХУ-ын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн зорилго нь улс орны технологийн бие даасан байдал, өрсөлдөх чадварыг хангах, үндэсний хөгжлийн зорилгод хүрэх, үндэсний стратегийн тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд оршино.

76. ОХУ-ын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн зорилгод хүрэх нь дараах зорилтыг шийдвэрлэх замаар явагдана.

1) Оросын эдийн засгийг шинэ технологийн үндэс рүү шилжүүлэхэд чиглэсэн зохицуулалттай бодлогыг холбооны, бүс нутаг, салбар, корпорацийн түвшинд боловсруулж хэрэгжүүлэх;

2) ОХУ-ын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд зарцуулсан зардлын түвшинг энэ чиглэлээр тэргүүлэх байр суурийг эзэлдэг гадаадын орнуудын ийм зорилгоор зарцуулах зардлын түвшинд хүргэх;

3) Шинжлэх ухаан, техник, инновацийн үйл ажиллагааг удирдах төрийн нэгдсэн тогтолцоог бий болгох;

4) Шинжлэх ухаан, техник, инновацийн үйл ажиллагааг хөгжүүлэх Оросын бизнесийн сонирхлыг нэмэгдүүлэх нөхцөл, хөшүүргийг бий болгох;

5) ОХУ-ын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн дагуу шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн бүрэн мөчлөгийг хангахын тулд шинжлэх ухааны судалгааны үр дүнг аж үйлдвэр, үйлдвэрлэлд нэвтрүүлэх явцыг хурдасгах;

6) ОХУ-ын тогтвортой хөгжлийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох шинжлэх ухааны суурь судалгааны тогтолцоог боловсронгуй болгох;

- 7) Шинжлэх ухаан, техник, инновацийн дэд бүтцийг шинэчлэх, хөгжүүлэх;
- 8) Шинжлэх ухааны байгууллага, дээд боловсролын боловсролын байгууллагуудын материал, техникийн бааз, түүний дотор багаж хэрэгсэл, туршилтыг шинэчлэх;
- 9) ОХУ-ын нутаг дэвсгэр дээр шинжлэх ухааны өндөр түвшний шинжлэх ухааны байгууламжийн сүлжээ, томоохон судалгааны дэд бүтэц, шинжлэх ухаан, технологийн тоног төхөөрөмж, туршилтын үйлдвэрлэл, инженерийн хамтын ажиллагааны төвүүдийг бий болгож хөгжүүлэх;
- 10) ОХУ-д ажиллах дэлхийн хэмжээний эрдэмтэн, залуу авьяаслаг судлаачдыг татах, ОХУ-ын нутаг дэвсгэрт шинжлэх ухаан, технологийн салбарт олон улсын хамтын ажиллагааны төвүүдийг бий болгон хөгжүүлэх;
- 11) Шинжлэх ухаан, техник, инновацийн үйл ажиллагааны чиглэлээр Оросын залуу эрдэмтэн, мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулах, сургах, зорилтот дэмжлэг үзүүлэх тогтолцоог хөгжүүлэх;
- 12) Шинжлэх ухаан, техник, инновацийн үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэх үндэсний тогтолцоог бий болгох;
- 13) Орос улс физик-математик, хими, биологи, анагаах ухаан, эм зүй, техникийн шинжлэх ухааны салбарт тэргүүлэх байр суурийг эзлэх;
- 14) Ирээдүйтэй өндөр технологи (нано технологи, робот техник, анагаах ухаан, биологи, генийн инженерчлэл, мэдээлэл, харилцаа холбоо, квант, хиймэл оюун ухаан, том өгөгдөл боловсруулах, эрчим хүч, лазер, нэмэлт, шинэ материал бүтээх, танин мэдэхүйн, байгальтай төстэй технологи) болон супер компьютерын системүүдийг хөгжүүлэх;
- 15) Салбар шинжлэх ухаан хоорондын судалгааг хөгжүүлэх;
- 16) Эрдэм шинжилгээний байгууллага, аж үйлдвэрийн аж ахуйн нэгжийн харилцан үйлчлэлийг бэхжүүлэх, шинжлэх ухаан, шинжлэх ухаан-техникийн хөгжлийг идэвхтэй арилжаалах нөхцөлийг бүрдүүлэх;
- 17) Улс орны батлан хамгаалах, улсын аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс шинжлэх ухаан, шинжлэх ухаан-техникийн судалгаа хийх;
- 18) ОХУ-ын биологи, цацраг, химийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр шинжлэх ухааны судалгааг идэвхжүүлэх;
- 19) Эдийн засгийн батлан хамгаалах болон эдийн засгийн иргэний салбарын хооронд мэдлэг, технологийн дамжуулалтыг хангах;
- 20) Оюуны өмчийг хамгаалах хэрэгслийг хөгжүүлэх, патентын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх практикийг өргөжүүлэх, Оросын технологи, хөгжлийг гадаадад хууль бусаар шилжүүлэхтэй тэмцэх;
- 21) ОХУ-д шинжлэх ухааны судалгаа, туршилтын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- 22) Оросын шинжлэх ухаан, шинэлэг бүтээгдэхүүний дотоодын эрэлт хэрэгцээ, ялангуяа төрийн үйлчлүүлэгчид, төрийн өмчит компаниуд, төрийн оролцоотой компаниудын эрэлтийг бүрдүүлэх;

23) ОХУ-ын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн тэргүүлэх чиглэлээр шинжлэх ухаан, шинжлэх ухаан-сурган хүмүүжүүлэх боловсон хүчин, өндөр мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх;

24) Орчин үеийн дэлхийн жишигт нийцүүлэн мэргэжилтэй ажилтан, дунд шатны мэргэжилтэн бэлтгэх зорилгоор дунд мэргэжлийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх.

Экологийн аюулгүй байдал, байгалийн нөөцийн зохистой ашиглалт

77. Сүүлийн хэдэн арван жилд дэлхийн үйлдвэрлэл, хэрэглээний эрчимтэй өсөлт нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн дарамтыг нэмэгдүүлж, түүний төрх байдлыг доройтуулж, дэлхий дээрх амьдралын нөхцөл байдлыг ихээхэн өөрчлөлтөд оруулж байна.

78. Байгалийн нөөцийг хайр найргүйгээр ашиглах нь газрын доройтол, хөрсний үржил шим буурах, усны нөөц хомсдох, далайн экосистемийн доройтол, ландшафт, биологийн олон янз байдал буурахад хүргэж байна. Байгаль орчны бохирдол нэмэгдэж, энэ нь хүний амьдралын чанарыг бууруулж байна. Олон улс орон байгалийн баялгийн хомсдолд орж байна.

79. Уур амьсгалын өөрчлөлт нь бизнесийн нөхцөл байдал, хүний хүрээлэн буй орчны төлөв байдалд улам бүр сөрөг нөлөө үзүүлж байна. Байгалийн болон гар аргаар үүссэн гамшгийн эх үүсвэр болох байгалийн аюул, үйл явцын давтамж нэмэгдэж байна.

80. Ногоон, нүүрстөрөгч багатай эдийн засгийг хөгжүүлэх нь олон улсын хэлэлцэх асуудлын нэг болоод байна. Байгалийн баялгийг ашиглахын төлөөх өрсөлдөөн нэмэгдэж байгаа нь олон улсын хурцадмал байдал, улс хоорондын зөрчилдөөн үүсэх нэг хүчин зүйл болж байна.

81. ОХУ-ын нутаг дэвсгэр, ландшафт, биологийн олон янз байдал, экологи, нөөцийн өвөрмөц нөөц бололцоог үндэсний баялаг гэж үздэг бөгөөд түүнийг хадгалах, хамгаалах нь хойч үеийнхний амьдрал, хүн төрөлхтний эв найртай хөгжлийг хангахад зайлшгүй шаардлагатай. Байгаль орчны стандартад нийцсэн агаар, усны чанарыг хадгалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, нутаг дэвсгэр, усны байгууламжийг экологийн хувьд нөхөн сэргээх, ойжуулалтын талбайг нэмэгдүүлэх, хуримтлагдсан байгаль орчны хохирлыг арилгах нь иргэдийн таатай орчинд амьдрах эрхийг хэрэгжүүлэх, хүний амьдралын чанарыг сайжруулах зайлшгүй нөхцөл юм.

82. Байгаль орчны аюулгүй байдлыг хангах, байгалийн зохистой менежментийн зорилго нь хүний таатай амьдрахад шаардлагатай байгаль орчны чанарыг хангах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцвэрт менежментийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

83. Байгаль орчны аюулгүй байдлыг хангах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах зорилгод хүрэх нь дараах зорилтыг шийдвэрлэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар хэрэгжинэ.

1) Байгаль орчинд ээлтэй эдийн засгийн өсөлтийг хангах, шинэлэг технологи нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

2) Байгалийн нөөцийг зохистой, үр ашигтай ашиглах, ашигт малтмалын баазыг хөгжүүлэх;

3) Хот болон бусад суурин газрын агаар мандлын агаарын бохирдлын түвшинг бууруулах;

4) Хүлэмжийн хийн ялгарлыг хянах төрийн зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингэлтийг нэмэгдүүлэх төслүүдийн хэрэгжилтийг хангах;

5) Агаар мандал, үйлдвэрлэлийн болон хотын бохир усыг цэвэрлэх байгууламж, технологийг хөгжүүлэх;

6) Ус цаг уурын аюулгүй байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх;

7) Гадаргын болон гүний усыг бохирдлоос урьдчилан сэргийлэх, бохирдсон усны биет дэх усны чанарыг сайжруулах, усны экосистемийг нөхөн сэргээх;

8) Үйлдвэрлэл, хэрэглээний хог хаягдлын хэмжээг бууруулах, тэдгээрийг устгах, дахин ашиглах үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

9) Хөрсний үржил шимийн бууралт, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хуримтлагдсан байгаль орчны хохирлыг арилгах, нутаг дэвсгэрийн экологийн нөхөн сэргээлт ;хийх

10) Байгалийн экосистемийн биологийн олон янз байдлыг хадгалах, тусгай хамгаалалттай байгалийн бүс нутгийн тогтолцоог хөгжүүлэх, ой мод, түүнчлэн амьтны ертөнцийн объект, түүний дотор усны биологийн нөөцийг хамгаалах, нөхөн үржүүлэх;

11) Бусад улсын нутаг дэвсгэрээс авчирсан бохирдуулагч бодис (цацраг идэвхт бодис орно) болон бичил биетээр хордогдох хүрээлэн буй орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх;

12) ОХУ-ын Арктикийн бүсийн байгаль орчны асуудлыг шийдвэрлэх, байгалийн нөөцийг зохистой ашиглах;

13) Байгаль орчныг хамгаалах чиглэлээр улсын байгаль орчны хяналт, үйлдвэрлэл, олон нийтийн хяналтын үр ашгийг нэмэгдүүлэх;

14) Аж ахуйн нэгжүүдэд байгаль орчны стандарт, байгаль орчны шаардлагыг дагаж мөрдүүлэх байгаль орчны улсын хяналт, хяналтын тогтолцоог хөгжүүлэх, байгалийн аюултай үзэгдэл, үйл явц, уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засгийн нөхцөл, хүний амьдралд үзүүлэх нөлөөллийн үр дагаврыг урьдчилан таамаглах, үр ашгийг нэмэгдүүлэх;

15) Биологийн аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зорилгоор биологийн эрсдлийн хяналтын системийг хөгжүүлэх;

16) Байгалийн болон гар аргаар үүссэн гамшиг ослын байгаль орчны сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, арилгах арга хэмжээнд оролцох хүчний техникийн чадавхи, техник хэрэгслийг нэмэгдүүлэх;

17) Иргэдийн байгаль орчны боловсрол, байгаль орчны соёлын түвшинг дээшлүүлэх, иргэдийн байгаль орчинд хариуцлагатай хандах хандлагыг төлөвшүүлэх, хүн ам, олон нийтийн байгууллагуудыг байгаль орчны үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход түлхэц өгөх;

18) ОХУ-ын хил орчмын бүс нутагт байгаль орчны эрсдэлийг бууруулах зорилгоор

байгаль орчныг хамгаалах чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх.

**Оросын уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлс,
соёл, түүхэн ой санамжийг хамгаалах**

84. Орчин үеийн ертөнцөд болж буй өөрчлөлтүүд нь улс хоорондын харилцаанд төдийгүй хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсэд нөлөөлж байна. Нийгэм, эдийн засаг, технологийн хөгжлийн өндөр түвшинд хүрсэн хүн төрөлхтөн уламжлалт оюун санааны болон ёс суртахууны удирдамж, тогтвортой ёс суртахууны зарчмуудыг алдах аюултай тулгарч байна.

85. Ёс суртахууны болон соёлын үндсэн хэм хэмжээ, шашны үндэс суурь, гэрлэлт, гэр бүлийн үнэт зүйлс улам бүр хор хөнөөлтэй нөлөөнд автсаар байна. Хувь хүний эрх чөлөөг үнэмлэхүй болгож, хүлцэнгүй байдал, ёс суртахуунгүй байдал, хувиа хичээсэн үзлийг идэвхтэй сурталчилж, хүчирхийлэл, хэрэглээ, таашаал ханамжийг тахин шүтэх үзлийг суулгаж, хар тамхины хэрэглээг хуульчилж, амьдралын жам ёсны үргэлжлэлийг үгүйсгэсэн нийгэмлэгүүд бий болж байна. Үндэстэн хоорондын болон шашин хоорондын харилцааны асуудал дайсагнал, үзэн ядалтыг бий болгодог геополитикийн тоглоом, таамаглалын сэдэв болж байна.

86. Түүхэн уламжлал, өмнөх үеийн туршлагыг харгалзахгүйгээр боловсрол, шинжлэх ухаан, соёл, шашин, хэл, мэдээллийн салбарт харийн үзэл санаа, үнэт зүйлийг төлөвшүүлэх, шинэчлэлийг хийх нь үндэсний нийгмийг хагарал, туйлшралд хүргэж соёлын тусгаар тогтнолын үндэс, улс төрийн тогтвортой байдал, төрт ёсны үндэс суурийг эвдэж байна. Ёс суртахууны үндсэн хэм хэмжээг өөрчлөх, сэтгэл зүйн заль мэх нь хүний ёс суртахууны эрүүл мэндэд нөхөж баршгүй хохирол учруулж, хор хөнөөлтэй зан үйлийг өдөөж, нийгмийн өөрөө өөрийгөө устгах нөхцөлийг бүрдүүлж байна. Залгамж үе үеийн ялгаа ихсэж байна. Үүний зэрэгцээ түрэмгий үндсэрхэг үзэл, гадныхныг үзэн ядах үзэл, шашны хэт даврагч үзэл, терроризмын илрэл улам бүр нэмэгдсээр байна.

87. Оросын уламжлалт оюун санаа, ёс суртахуун, соёл, түүхийн үнэт зүйлсэд АНУ болон түүний холбоотнууд, түүнчлэн үндэстэн дамнасан корпорациуд, гадаадын ашгийн бус болон төрийн бус байгууллагууд, шашны, хэт даврагч, террорист байгууллагууд идэвхтэй халдаж байна. Тэд ОХУ-ын ард түмний уламжлал, итгэл үнэмшилд харш нийгэм, ёс суртахууны хандлагыг түгээн дэлгэрүүлэх замаар хувь хүн, бүлэг, олон нийтийн ухамсарт мэдээлэл, сэтгэлзүйн нөлөөзүүлж байна .

88. Мэдээлэл-сэтгэлзүйн хорлон сүйтгэх ажиллагаа, соёлыг «баруунжуулах» нь ОХУ-ын соёлын бүрэн эрхээ алдах аюулыг нэмэгдүүлж байна. Оросын болон дэлхийн түүхийг гуйвуулах, түүхэн үнэнийг гажуудуулах, түүхэн ой санамжийг устгах, үндэстэн, шашин хоорондын мөргөлдөөнийг өдөөн турхирах, төрийг бүрдүүлэгч ард түмнийг сулруулах оролдлого улам бүр газар авчээ.

89. Оросын уламжлалт шашин шүтлэг, соёл, орос хэлийг гутааж байна.

90. ОХУ нь үндэсний түүхийн олон зуун жилийн туршид бүрэлдэн бий болсон өөрийн үндсэн оюун санаа, ёс суртахууны болон соёл-түүхийн үнэт зүйлс, ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээг Оросын нийгмийн үндэс суурь гэж үздэг нь Оросын бүрэн эрхт байдлыг хадгалах боломжийг олгож ирээдүйгээ бүтээх, нийгэм, хувь хүний хөгжлийн шинэ өндөрлөгт хүрэх байдлыг бэхжүүлж байна.

91. Оросын уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлд юуны түрүүнд амь нас, нэр төр, хүний эрх, эрх чөлөө, эх оронч үзэл, иргэншил, эх орондоо үйлчлэх, хувь заяаны төлөө хариуцлага хүлээх, ёс суртахууны өндөр үзэл санаа, бат бөх гэр бүл, бүтээлч ажил, материаллаг байдлаас илүү оюун санааны тэргүүлэх үзэл өршөөл, шударга ёс, хамтын үзэл, харилцан туслалцах, харилцан хүндэтгэх байдал, түүхэн ой санамж, үе үеийн залгамж чанар, Оросын ард түмний эв нэгдэл зэрэг оюун санааны тэргүүлэх чиглэлүүд орох бөгөөд энэхүү Оросын уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлс нь манай олон үндэстэн, олон шашинт улсыг нэгтгэдэг.

92. Оросын уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлс, соёл, түүхэн ой санамжийг хамгаалах нь бүх Оросын иргэний өвөрмөц байдлын үндэс, хүн төрөлхтний анхны түгээмэл зарчим, нийгмийн хөгжлийн ач холбогдол бүхий чиг хандлага удирдамжид тулгуурлан Оросын ард түмний эв нэгдлийг бэхжүүлэх зорилгоор хийгддэг юм.

93. Оросын уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлс, соёл, түүхэн ой санамжийг хамгаалах нь дараах асуудлыг шийдвэрлэх замаар хангагдана.

1) Иргэний эв нэгдэл, бүх Оросын иргэний өвөрмөц байдал, үндэстэн хоорондын болон шашин хоорондын эв найрамдлыг бэхжүүлэх, ОХУ-ын олон үндэстний ард түмний өвөрмөц байдлыг хадгалах;

2) Түүхэн үнэнийг хамгаалах, түүхэн ой санамжийг хадгалах, Оросын төрийн хөгжил, түүний түүхэн нэгдмэл байдлын тасралтгүй байдал, түүхийг хуурамчаар үйлдэхтэй тэмцэх;

3) Гэр бүлийн институцийг бэхжүүлэх, гэр бүлийн уламжлалт үнэт зүйлсийг хадгалах, оросуудын үе үеийн залгамж чанарыг хадгалах;

4) Олон нийтийн ухамсарт Оросын уламжлалт оюун санаа, ёс суртахуун, соёл, түүхийн үнэт зүйлсийн үүргийг бэхжүүлэх, иргэдийг гаднын нөлөөнд автсан хор хөнөөлтэй санаа, хэвшмэл ойлголт, зан үйлээс таггалзахад чиглэсэн төрийн мэдээллийн бодлогыг хэрэгжүүлэх;

5) Оюун санаа, ёс суртахуун, бие бялдрын хувьд төгс төгөлдөрт хүрэхийг эрмэлздэг хөгжингүй, нийгмийн хариуцлагатай хүнийг төлөвшүүлэх үндэст суурилсан боловсрол, сургалт, хүмүүжлийн тогтолцоог хөгжүүлэх;

6) Иргэдийн эх оронч хүмүүжил, ОХУ-ын ард түмний түүхэн ой санамж, соёлыг хадгалахад чиглэсэн олон нийтийн төслүүдийг дэмжих;

7) ОХУ-ын соёлын тусгаар тогтнолыг бэхжүүлэх, соёлын нийтлэг орон зайг хадгалах;

8) Оросын ард түмний биет болон биет бус соёлын өвийг хадгалах, Оросын шинжлэх ухаан, технологи, уран зохиол, урлаг соёл, хөгжим, спортын ололтыг сурталчлах, түүний дотор боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөрийг эцэслэн боловсруулах;

9) Түүхэн болон орчин үеийн жишээн дээр үндэслэсэн иргэдийн оюун санааны, ёс суртахууны болон эх оронч үзлийн боловсрол, Оросын нийгмийн хамтын зарчмуудыг хөгжүүлэх, нийгмийн ач холбогдолтой санаачилга, түүний дотор буяны төсөл, сайн дурын хөдөлгөөнийг дэмжих;

10) Уламжлалт шашны байгууллагуудыг дэмжих, Оросын уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлсийг хадгалах, Оросын нийгмийг уялдуулах, шашин хоорондын яриа хэлэлцээний соёлыг түгээх, хэт даврагч үзэлтэй тэмцэхэд чиглэсэн үйл ажиллагаанд тэдний оролцоог хангах;

11) Соёл, түүхэн үнэнийг хамгаалах, түүхэн ой санамжийг хадгалах, шинжлэх ухааны судалгаа хийх, шинжлэх ухааны түгээмэл материал хэвлэх, уран зохиол, урлаг, кино урлаг, театр, телевиз, видео, интернэт бүтээгдэхүүн бий болгох, Оросын уламжлалт оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлийг хадгалахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх, улсын захиалга бий болгох, түүнчлэн энэхүү төрийн даалгаврын хэрэгжилтэд чанарын хяналтыг хангах;

12) Орос хэлийг ОХУ-ын төрийн хэл болгон хамгаалах, дэмжих, орчин үеийн Оросын утга зохиолын хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх хяналтыг бэхжүүлэх, тогтоосон хэм хэмжээг дагаж мөрдөөгүй болон садар самуун үгсийн сан үг, хэллэг агуулсан бүтээгдэхүүнийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх зэрэг олон нийтийн сөрөг үйл ажиллагааг таслан зогсоох;

13) Оросын нийгмийг гаднын үзэл суртлын болон үнэлэмжийн тэлэлт, гаднын хор хөнөөлтэй мэдээлэл, сэтгэл зүйн нөлөөллөөс хамгаалах, хэт даврагч агуулгатай бүтээгдэхүүн, хүчирхийллийг сурталчлах, арьс өнгө, шашны үл тэвчих байдал, үндэстний үзэн ядалтаас урьдчилан сэргийлэх;

14) Дэлхийн хүмүүнлэг, соёл, шинжлэх ухаан, боловсролын орон зайд Оросын үүргийг нэмэгдүүлэх.

Стратегийн тогтвортой байдал, харилцан ашигтай олон улсын хамтын ажиллагаа

94. Дэлхийн хөгжлийн чадавхыг дахин хуваарилах, дэлхийн дэг журмын шинэ архитектур, дүрэм, зарчмуудыг бүрдүүлэх нь геополитикийн тогтворгүй байдлыг улам бүр нэмэгдүүлж, улс хоорондын зөрчилдөөн, мөргөлдөөнийг хурцатгаж байна.

95. Маргаангүйгээр манлайллаа алдаж буй улс орнууд олон улсын хамтын нийгэмлэгийн бусад гишүүнд өөрсдийн дүрэм журмыг зааж өгөхийг оролдож, шударга бус өрсөлдөөний арга хэрэгслийг ашиглах, хязгаарлах арга хэмжээ (хориг) дангаараа хэрэглэх, бүрэн эрхт улсуудын дотоод хэрэгт илт хөндлөнгөөс оролцохыг оролдож байна. Ийм үйлдлүүд нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, хэм хэмжээг сулруулж, олон улсын эрх зүйн зохицуулалтын одоо байгаа институци, дэглэмийг сулруулж, устгах, цэрэг-улс төрийн байдлыг хурцатгах, урьдчилан таамаглах чадварыг бууруулах, улс хоорондын харилцааны итгэлцлийг сулруулахад хүргэж байна.

96. ОХУ нь үндэсний эрх ашгийг хамгаалах, олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн тууштай, бие даасан, олон талт, нээлттэй, урьдчилан таамаглах боломжтой, прагматик гадаад бодлогыг баримталж байна.

97. ОХУ нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг болзолгүй дагаж мөрдөх, дэлхийн болон бүс нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд НҮБ, түүний Аюулгүйн зөвлөлийн төвлөрсөн зохицуулах үүргийг бэхжүүлэх үндсэн дээр олон улсын харилцаан дахь тогтолцооны тогтвортой байдлыг хангахыг эрмэлздэг.

98. ОХУ улс хоорондын харилцааны урьдчилан таамаглах чадварыг нэмэгдүүлэх, олон улсын хүрээнд итгэлцэл, аюулгүй байдлыг бэхжүүлэхийг эрмэлзэж байна. Дэлхийн шинэ дайн дэгдээх аюулыг бууруулах, зэвсгээр хөөцөлдөхөөс урьдчилан сэргийлэх, түүнийг шинэ орчинд шилжүүлэхээс зайлсхийхийн тулд стратегийн тогтвортой байдлыг хангах, зэвсгийн хяналт, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэх механизмыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

99. Орос улс олон улсын болон дотоодын мөргөлдөөнийг зохицуулахад улс төрийн арга хэрэгсэл, юуны өмнө дипломат болон энхийг сахиулах механизмыг ашиглах байр суурин дээр тууштай хэвээр байна. Гадаадын улс орнууд ОХУ-ын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд заналхийлж буй найрсаг бус үйлдэл, түүний дотор улс төр, эдийн засгийн шинж чанартай хязгаарлалтын арга хэмжээ (хориг) хэрэглэх, орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны технологи хэрэгслийг ашиглахтай холбоотой үйлдлүүд хийсэн тохиолдолд ОХУ эдгээр дайсагнасан үйлдлүүдийг зогсоох, түүнчлэн ирээдүйд дахин давтагдахаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай тэгш хэмтэй болон тэгш бус арга хэмжээ авахыг хууль ёсны гэж үзэж байна.

100. ОХУ-ын гадаад бодлогын зорилтууд нь улс орны нийгэм, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, ОХУ-ын орчин үеийн ертөнцөд нөлөө бүхий төвүүдийн нэг болох байр суурийг бэхжүүлэх явдал юм.

101. ОХУ-ын гадаад бодлогын зорилгод хүрэх нь дараах зорилтыг шийдвэрлэх замаар явагдана.

1) Олон улсын эрх зүйн тогтолцооны тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, түүнийг хуваагдал, олон улсын эрх зүйн хэм хэмжээг сулруулах, сонгон хэрэглэхээс урьдчилан сэргийлэх;

2) Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, НҮБ-ын дүрмийг зөрчиж цэргийн хүч хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, дэлхийн дайныг өдөөх урьдчилсан нөхцөл, цөмийн зэвсэг ашиглах эрсдэлийг арилгах;

3) Дэлхийн болон бүс нутгийн түвшинд хамтын аюулгүй байдлыг хангах механизмыг боловсронгуй болгох, итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, шаардлагатай бол хөгжүүлэх, цэргийн салбарт гарч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх;

4) Стратегийн тогтвортой байдлыг хангах, үй олноор хөнөөх зэвсгийг түгээн дэлгэрүүлэхгүй байх механизм, түүнийг хүргэх хэрэгсэл, холбогдох технологи, зэвсгийн хяналтын механизм, түүнчлэн биотехнологийг бий болгох, ашиглах чиглэлээр хариуцлага, хяналтын механизмыг боловсронгуй болгох;

5) ТУХН-ийн гишүүн орнууд, Бүгд Найрамдах Абхаз Улс, Өмнөд Осетийн Бүгд Найрамдах Улстай хоёр талын үндсэн дээр, тэгш эрхийн холбоодын хүрээнд, ялангуяа Евразийн эдийн засгийн холбоо, Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага, Холбооны улстай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх;

6) Их Евразийн түншлэлийн хүрээнд эдийн засгийн тогтолцооны нэгдмэл байдлыг хангах, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх;

7) Бүгд Найрамдах Энэтхэг Улстай онцгой давуу эрх бүхий стратегийн түншлэлийн

харилцаатай болох, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай иж бүрэн түншлэлийн харилцаа, стратегийн хамтын ажиллагаа, тэр дундаа Ази, Номхон далайн бүс нутагт бүс нутгийн тогтвортой байдал, аюулгүй байдлыг хангах найдвартай механизмыг бий болгох зорилгоор блок бус суурийг хөгжүүлэх;

8) Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, БРИКС-ийн форматаар гадаад улс орнуудтай олон талт хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, БРИКС-ийн хүрээнд Орос, Энэтхэг, Хятадыг оролцуулсан РИК-ийн харилцан үйлчлэлийн болон институцийн үндсийг бэхжүүлэх;

9) Ази, Номхон далайн бүс нутаг, Латин Америк, Африк зэрэг олон талт олон улсын институци, яриа хэлэлцээний платформ, бүс нутгийн холбоодын хүрээнд бүс нутгийн болон дэд бүсийн интеграцлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

10) Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын болон бүс нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхийн тулд сонирхогч бүх улстай эрх тэгш, харилцан ашигтай яриа хэлэлцээг явуулах;

11) ОХУ-тай хөрш зэргэлдээ улсуудын нутаг дэвсгэрт хурцадмал байдал, мөргөлдөөний голомтыг арилгах, урьдчилан сэргийлэхэд туслалцаа үзүүлэх;

12) Энхийг сахиулах ажиллагаанд ОХУ-ын үүргийг нэмэгдүүлэх;

13) ОХУ-ын холбоотон, түншүүдэд батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, тэдний дотоод хэрэгт гаднын хөндлөнгийн оролцоог саармагжуулах;

14) ОХУ-ын иргэд, ОХУ-ын аж ахуйн нэгжүүдийн гадаад дахь эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

15) Оросын бараа бүтээгдэхүүн, түүний дотор өндөр технологийн бүтээгдэхүүнийг экспортлоход дэмжлэг үзүүлэх, шударга бус өрсөлдөөнийг ашиглах, Оросын компаниудыг ялгаварлан гадуурхахыг эсэргүүцэх;

16) Олон улсын худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт, дэвшилтэт технологи, өндөр мэргэшсэн мэргэжилтнүүдийг ОХУ-д татахад туслалцаа;

17) Сансар огторгуй, дэлхийн далай, Хойд мөсөн болон Антарктидыг судлахтай холбоотой ОХУ-ын ашиг сонирхлыг хангах;

18) Дэлхийн хүмүүнлэг, соёл, шинжлэх ухаан, боловсролын орон зайд ОХУ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, олон улсын харилцааны хэл болох орос хэлний байр суурийг бэхжүүлэх;

19) Гадаадад амьдарч буй эх орон нэгтнүүдэд эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, түүний дотор бүх Оросын соёлын өвөрмөц байдлыг хадгалах эрхийг хангах, тэдний ашиг сонирхлыг хамгаалах;

20) Орос, Беларусь, Украины ард түмний ах дүүгийн харилцааг бэхжүүлэх;

21) Түүхийг хуурамчаар үйлдэх оролдлогын эсрэг тэмцэх, түүхэн үнэнийг хамгаалах, түүхэн ой санамжийг хадгалах;

22) Дэлхийн мэдээллийн орон зайд Оросын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн харилцааны байр суурийг бэхжүүлэх;

23) Олон улсын байгууллага, институциудын хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх, сүлжээний дипломатын арга хэрэгслийн хэрэглээг өргөжүүлэх;

24) Гадаад улстай цэрэг-улс төрийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;

25) Терроризм, экстремизм, авлига, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус үйлдвэрлэл, эргэлт, хууль бус шилжилт хөдөлгөөн, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

26) Дэлхийн мэдээллийн аюулгүй, тэгш орон зайг бий болгох ашиг сонирхлын үүднээс олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

27) Байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гадаад улстай харилцах харилцааг хөгжүүлэх;

28) Байгалийн болон гар аргаар үүссэн гашиг ослын үр дагаврыг арилгах, биологийн аюул занал, аюултай халдварт өвчний тархалттай тэмцэхэд гадаадын улс орнуудад тусламж үзүүлэх ;

29) Дэлхийн тээврийн орон зайд нэгдэн оролцох, ОХУ-ын дамжин өнгөрөх боломжийг хэрэгжүүлэх;

30) Олон улсын хөгжлийн тусламж үзүүлэх ялангуяа Зөвлөлтийн дараах орон зайд хамтын ажиллагааг идэвхжүүлэх;

31) Орос ба гадаад улс орнууд олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, харилцан ашигтай арга барилыг бий болгох, эдийн засгийн харилцан туслалцаа үзүүлэх, шинэ технологи хөгжүүлэхтэй холбоотой асуудлууд болон нийгэм, хүмүүнлэгийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн ажлыг Зөвлөлтийн дараах орон зайд хэрэгжүүлэх;

32) Биологийн аюулгүй байдлыг бэхжүүлэх чиглэлээр ТУХН-ийн гишүүн орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх.

ТАВ. ЭНЭХҮҮ СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮНДЭС, МЕХАНИЗМ

102. Төрийн байгууллага үйл ажиллагаандаа энэхүү стратегийн заалтыг удирдлага болгон ажиллана.

103. Энэхүү стратегийн хэрэгжилтийг ОХУ-ын Ерөнхийлөгчийн удирдлага дор төрийн эрх мэдэл, байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын улс төр, зохион байгуулалт, нийгэм-эдийн засаг, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг стратегийн төлөвлөлтийн хүрээнд боловсруулсан хууль эрх зүй, мэдээллийн, цэргийн, тусгай болон бусад арга хэмжээнүүдийг цогц байдлаар хэрэгжүүлэх замаар төлөвлөгөөт байдлаар хангана.

104. Үндэсний стратегийн тэргүүлэх зорилтуудын хүрээнд дэвшүүлсэн зорилтыг ОХУ-ын үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах чиглэлээр стратеги төлөвлөлтийн баримт бичиг, хөтөлбөр, төслийг боловсруулах, тохируулах,

шаардлагатай нөөцийн дэмжлэг үзүүлэх хэрэгжүүлэх замаар шийдвэрлэнэ.

105. Энэхүү Стратегийн хэрэгжилтэд тавих хяналтыг ОХУ-ын Ерөнхийлөгчийн тогтоосон үндэсний аюулгүй байдлын төлөв байдлын үзүүлэлтүүдийн үндсэн дээр үндэсний аюулгүй байдлын байдалд хийх төрийн хяналт шалгалтын хүрээнд хэрэгжүүлнэ. Ийм хяналтын үр дүнг ОХУ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын ОХУ-ын Ерөнхийлөгчид үндэсний аюулгүй байдлын байдал, түүнийг бэхжүүлэх арга хэмжээний тухай жил бүрийн тайланд тусгана.

106. Энэхүү Стратегийн хэрэгжилт нь ОХУ-ын үндэсний аюулгүй байдал, нийгэм-эдийн засгийн хөгжлийг хангах чиглэлээр төрийн захиргааны болон стратеги төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгоход чиглэнэ.

Энэхүү стратегийг хэрэгжүүлэх нь Оросын ард түмнийг аврах, хүний нөөцийг хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанар, сайн сайхан байдлыг дээшлүүлэх, улс орны батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх, Оросын нийгмийн эв нэгдэл, эв нэгдлийг бэхжүүлэх, үндэсний хөгжлийн зорилгод хүрэх, өрсөлдөх чадвар, ОХУ-ын олон улсын нэр хүндийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болно.